



4 ФИНТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СЭНДБОКСЫН ДАРААХ ЗОХИЦУУЛАЛТ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Батчимэг, Э.Элбэгзаяа, О.Мичидмаа

ХУРААНГУЙ:

Технологид суурилсан санхүүгийн салбар хурдацтай өсөн, технологийн шинэчлэл, зохицуулалтын өөрчлөлтүүдийг авчирч байна. Энэ салбар нь уламжлалт санхүүгийн үйлчилгээний хязгаарлалтыг давж, илүү хүртээмжтэй, үр ашигтай, аюулгүй санхүүгийн орчныг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ улс орнууд шинээр бий болж буй эрсдэл, боломжид нийцүүлэн нэгдсэн “Финтекийн тухай хууль” батлах, салбар тус бүрийн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зохицуулалтын сэндрокс зэрэг туршилтын уян хатан механизмыг нэвтрүүлэх зэргээр олон төрлийн зохицуулалтын арга хэрэгсэл ашиглаж байна. Монгол Улсад финтекийн салбар эрчимтэй хөгжиж байгаа ч салбаруудын хууль эрх зүйн шинэчлэл хурдтай бус байгаагаас шалтгаалан шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд туршилтаас хэтэрч зах зээлд бүрэн эрхтэйгээр нэвтрэхэд эрх зүйн орчин тодорхой бус, хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь инновацыг удаашруулах, хөрөнгө оруулагчдын итгэл сулрах, хэрэглэгчийн эрх зүйн хамгаалалт хангалтгүй байх зэрэг эрсдэлийг дагуулж байна. Энэхүү судалгаа нь Мексик, Сингапур, БНСУ, Казахстан, Их Британи зэрэг найман орны финтекийн зохицуулалтын эрх зүйн тогтолцоог харьцуулан судалж, тэдгээрийн сэндроксын дараах үеийн зохицуулалтын шийдэл, тусгай зөвшөөрлийн аргачлал, эрх зүйн механизмыг үнэлсэн болно. Судалгааны үр дүнд инновац дэмжсэн, эрсдэлд суурилсан, технологид төвийг сахисан зохицуулалт хамгийн үр дүнтэй болох нь харагдсан.

Түлхүүр үгс: Санхүүгийн технологи (финтек), финтекийн зохицуулалт, сэндрокс, хууль, эрх зүй, олон улсын бодлого, зохицуулалт, инновац.

JEL ангилал: G28, K20, K23, L51.

¹ СЗХ, ЗЗСХГ, Сэндроксын албаны дарга, batchimeg_b@frc.mn

² СЗХ, ЗЗСХГ, Сэндроксын албаны ахлах мэргэжилтэн, elbegzaya@frc.mn

³ СЗХ, ЗЗСХГ, Сэндроксын албаны мэргэжилтэн, michidmaa_o@frc.mn

АГУУЛГА

I.	УДИРТГАЛ	126
II.	ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ	128
2.1	Финтекийн зах зээлийн үүсэл, хөгжил	128
2.2	Финтекийн салбарын голлох чиг хандлага	130
2.3	Финтекийн салбарт ашиглагдаж буй технологиуд	131
2.4	Финтекийн салбарын зохицуулалт сорилт, боломж	133
III.	УЛС ОРНУУДЫН ФИНТЕКИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	134
3.1.	Бүс нутгийн финтекийн эрх зүйн зохицуулалт	135
3.1.1	Европын холбоо болон Европын бүсийн орнууд	135
3.1.2	Ази, Номхон далайн бүс	136
3.1.3	Хойд Америк ба Латин Америкийн орнууд	136
3.1.4	Зүүн Европ болон Төв Азийн бүс	136
3.1.5	Африк болон Ойрх Дорнодын бүс	137
3.2	Улс орнуудын финтекийн эрх зүйн зохицуулалт	138
3.2.1	Мексик Улс	138
3.2.2	Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)	140
3.2.3	Казахстан Улс	142
3.2.4	Сингапур Улс	143
3.2.5	Япон Улс	144
3.2.6	Филиппин Улс	146
3.2.7	Их Британи Улс	148
3.2.8	Швейцар Улс	151
3.2.9	Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт	155
IV.	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ФИНТЕК САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ	157
V.	ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА	159

ДҮГНЭЛТ, САНАЛ	161
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	163
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. Финтекийн зах зээлийн үүсэл, хөгжил	129
Хүснэгт 2. Финтекийн голлох сегментүүд	131
Хүснэгт 3. Бүс нутгийн финтекийн эрх зүйн зохицуулалт, бодлогын чиг хандлага	138
Хүснэгт 4. Улс орнуудын финтекийн зохицуулалт	153
Хүснэгт 5. Олон улсын байгууллагуудын финтек салбарт баримталж буй бодлого, баримт бичиг	157

I. УДИРТГАЛ

Сүүлийн арван жилийн хугацаанд финтекийн (санхүүгийн технологи) хурдацтай хөгжил нь дэлхийн санхүүгийн тогтолцооны бүтэц, үйлчилгээний суурь загварыг үндсээр нь өөрчилж байна. Цахим сүлжээ, гар утасны технологи, өгөгдлийн дүн шинжилгээ, блокчэйн, хиймэл оюун ухаан зэрэг технологийн ахиц дэвшил нь хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй, хялбар, зардал багатай, хэрэглэгч төвтэй санхүүгийн үйлчилгээг санал болгох замаар уламжлалт банкны тоглогчдод өрсөлдөөн үүсгэж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлж байна.

Финтекийн үйлчилгээ нь хөгжиж буй орнуудад банкны салбарын хүрээг тэлэх, албан бус санхүүгийн хэрэглээг бууруулах, зээлийн хүртээмжийг сайжруулах, мөнгөн гуйвуулгыг хөнгөвчлөх зэрэг олон боломжийг нээж, иргэдийн санхүүгийн оролцоог гүнзгийрүүлж байгаа бол хөгжингүй орнуудад хэрэглэгчийн туршлагыг сайжруулах, өгөгдөлд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын үйлчилгээг автоматжуулахад чиглэж байна. Тиймээс финтек нь зөвхөн нэгэн төрлийн технологийн үзэгдэл бус, харин дэлхийн эдийн засгийн бүтэц, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалтын хэлбэрт цогц нөлөө үзүүлж байна.

Олон улсын туршлагаас харахад финтекийн зохицуулах үндсэн гурван арга хэлбэр төлөвшиж байна. Үүнд: (1) нэгдсэн буюу

цогц финтек хууль батлах (жишээлбэл, Мексик), (2) салангид хуулиудыг шинэчлэх, үйлчилгээ тус бүрийг оновчтойгоор хамруулах (жишээлбэл, Их Британи), (3) туршилтын орчин, зарчимд суурилсан уян хатан зохицуулалт нэвтрүүлэх (жишээлбэл, Сингапур, Өмнөд Солонгос) зэрэг болно. Эдгээрийн аль ч арга нь технологийн хөгжилтэй нийцэж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, системийн эрсдэлийг бууруулах, инновацын орчныг дэмжих олон талт зорилтыг агуулж байна.

Монгол Улсад финтекийн салбар эрчимтэй хөгжиж байгаа ч хууль, эрх зүйн орчин нь бүрэн хөгжөөгүй, мөн салбаруудын хуулиудад цаг үеийн хөгжлийг даган шинэ өөрчлөлтүүд тусгахад хугацаа их шаардагддаг нь шинэ технологийг зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхэд тодорхой хязгаар үүсгэж байна. 2021 оноос Санхүүгийн зохицуулах хорооноос сэндрокс зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн нь инновацыг дэмжихэд чухал алхам боловч, сэндроксод амжилттай туршигдсан болон шинэ тутам хөгжиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах хуулийн зохицуулалт дутмаг хэвээр байна.

Энэхүү судалгаа нь улс орнуудын финтекийн хууль, эрх зүйн зохицуулалт, түүний үр нөлөө, зохицуулалтын ялгаа, зохицуулалтын арга барил зэрэг асуудлыг хамарч, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, инновацыг

дэмжихийн зэрэгцээ, зах зээл дэх эрсдэлийг бууруулах өөрийн улсын онцлогт тохирсон бодлого, зохицуулалтын арга барилыг тодорхойлох зорилготой юм. Судалгаа нь нийт 6 бүлэгтэй ба финтекийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн, энэ чиглэлд тэргүүлж буй холбогдох 8 улсыг сонгон тэдгээр улсын хууль, эрх зүйн зохицуулалт, арга барилыг судалсан. Судалгааны хоёрдугаар бүлэгт финтекийн зах зээл, түүний хөгжлийн талаар, гуравдугаар бүлэгт улс орнуудын финтекийн эрх зүйн зохицуулалтын талаар, дөрөвдүгээр бүлэгт олон улсын байгууллагуудын финтек зохицуулалтын талаар баримталж буй бодлого, баталсан холбогдох баримт бичгүүд, тавдугаар бүлэгт финтек, түүний зохицуулалтын цаашдын чиг хандлага, сүүлийн бүлэгт судалгааны дүгнэлт, саналыг тус тус тусгалаа.

Судалгааны асуудал:

Монгол Улсад финтекийн үйлчилгээ хурдацтай хөгжиж буй ч, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон эрх зүйн орчин нь тодорхой бус, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлүүдийг холбогдох хууль, тогтоомжид оруулахад хугацаа их шаардагдаж байна. Иймд олон улсын эрх зүйн хандлагыг харьцуулан судалж, Монголд хамгийн тохиромжтой зохицуулалтын

загварыг тодорхойлох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Судалгааны зорилго:

Улс орнуудын финтекийн зохицуулалтын хууль, бодлогын туршлагыг харьцуулан судалж, сэндрбоксын дараах зохицуулалтын шийдэл, эрх зүйн механизмыг тодорхойлох замаар Монгол Улсад инновац дэмжсэн, эрсдэлд суурилсан, уялдаа бүхий финтекийн зохицуулалтын загварыг боловсруулж, бодлогын санал, зөвлөмж гаргах.

Зорилтын хүрээнд:

1. Финтек үйлчилгээний төрлүүд болон хуулийн зохицуулалтын ерөнхий чиг хандлагыг бүс нутаг болон улс орноор харьцуулан судлах;
2. Зохицуулалтын сэндрбоксоос амжилттай туршсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн зах зээлд албан ёсоор нэвтрүүлж буй бодлого, эрх зүйн зохицуулалтыг судлах;
3. Монгол Улсын финтекийн эрх зүйн орчны өнөөгийн байдлыг тодорхойлж, олон улсын шилдэг туршлагад үндэслэн хууль, бодлогын шинэчлэлд тохирох санал, зөвлөмж боловсруулах.

II. ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ

2.1. ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Финтекийн түүхэн хөгжлийг олон улсын судалгаанд нийтлэгээр гурван үндсэн үе шаттайгаар тайлбарладаг. Арнер, Барберис, Бакли (2017)-ийн ангиллын дагуу эхний үе шат нь 1967–2007 оны хооронд үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд банк, санхүүгийн байгууллагууд дотоод үйл ажиллагаандаа цахим систем нэвтрүүлж, мөнгөн гүйлгээний автомат машин (ATM), олон улсын шилжүүлгийн систем (SWIFT), үндсэн өгөгдлийн сан (core banking systems) зэрэг технологид тулгуурлан үйл ажиллагаагаа автоматжуулж эхэлсэн. Хоёрдугаар үе шат нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа эхэлсэн бөгөөд энэхүү хямрал нь уламжлалт банкны үйлчилгээнд итгэх итгэлийг бууруулж, хэрэглэгч төвтэй, технологид суурилсан шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээ үүсэх нөхцөл болж өгсөн. Энэ үед хүн хоорондын зээл (peer-to-peer зээл), цахим төлбөрийн үйлчилгээ, ухаалаг гарутсанд суурилсан банкныхэрэглээ өргөжин хөгжсөн. Харин гуравдугаар үе шат нь 2015 оноос эхэлсэн гэж үздэг бөгөөд

энэ үеэс хиймэл оюун ухаан, блокчейн технологи (blockchain), өгөгдлийн автомат боловсруулалт, нээлттэй банкны интерфэйс (open banking API) зэрэг дэвшилт технологид тулгуурлан финтек нь уламжлалт тогтолцоог даван бие даасан үйлчилгээний экосистем болон төлөвшжээ (Arner et al., 2017). Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд зарим судлаачид (Gomber et al., 2018) болон олон улсын байгууллагууд (Дэлхийн банк, Олон улсын валютын сан) технологийн нөлөө, бодлогын хариу үйлдлийг илүү нарийвчлан судалж, финтекийн хөгжлийг таван үе шаттайгаар ангилах хандлага гаргаж ирсэн. Энэхүү ангилал нь сүүлийн үеийн шинэчлэлүүд болох төв банкны цахим валют (central bank digital currency), зохицуулагч байгууллагын хяналтын технологи (supervisory technology буюу SupTech), төвлөрсөн бус санхүүгийн платформ (decentralized finance буюу DeFi), платформд суурилсан үйлчилгээ (platform-based finance) зэрэг шинэ үзэгдлийг онцлон авч үздэг (Gomber et al., 2018; World Bank, 2020).

Хүснэгт 1. Финтекийн зах зээлийн үүсэл, хөгжил

Үе шат	Хугацаа	Үндсэн онцлог	Ашиглагдсан технологи	Бизнесийн загвар	Эрх зүйн хандлага
Цахим суурь бүрдсэн үе	1960–2007 он	Санхүүгийн байгууллагууд дотоод үйл ажиллагаагаа цахимжуулсан	Мөнгөн гүйлгээний автомат машин (АТМ), олон улсын шилжүүлгийн сүлжээ (SWIFT), төв өгөгдлийн систем	Банкнуудын дотоод автомат-жуулалт	Тусгай зохицуулалт хийгдээгүй
Интернэт банк, хэрэглэгч төвтэй үйлчилгээ	2008–2014 он	Дэлхийн санхүүгийн хямралын дараа хэрэглэгчдэд чиглэсэн финтек үйлчилгээнүүд үүссэн	Ухаалаг гар утас, цахим төлбөр, хэрэглэгчийн мэдээлэлд суурилсан систем	Хүн хоорондын зээл (peer-to-peer), цахим хэтэвч, зээлийн платформ	Хамрах хүрээ хязгаарлагдмал, хууль тогтоомжид захирагдахгүй шинэ хэлбэрүүд гарч ирсэн
Бие даасан финтек экосистем үүссэн үе	2015–2019 он	Финтек нь уламжлалт тоглогчдоос тусгаарлан өөрийн платформтой болсон	Хиймэл оюун ухаан, блокчэйн, өгөгдөлд суурилсан автомат систем, нээлттэй санхүүгийн холболт (API)	Цахим банк, хөрөнгө оруулалтын автомат зөвлөгч, нээлттэй санхүү	Зохицуулалтын туршилтын орчин (сэндбокс), шинэчлэгдсэн заавар, журам гарсан
Үндэсний бодлоготой уялдсан хөгжил	2020–2022 он	Засгийн газар, төв банкнуудын бодлогод финтек стратегийн түвшинд тусгагдсан	Төвлөрөлгүй сүлжээ, алгоритмд суурилсан үйлчилгээ, үүлэн тооцоолол	Платформд суурилсан банк, хувийн дижитал зөвлөгч	Хувь хүний мэдээлэл хамгаалах, өгөгдөл ашиглах зохицуулалт бий болсон
Уялдсан зохицуулалт ба шинэтгэлийн эдийн засаг	2023 оноос	Төв банкны цахим валют, зохицуулагчдын дижитал хяналт, олон улсын платформын уялдаа	Төв банкны цахим валют (CBDC), хяналтын технологи (SupTech), төвлөрсөн бус санхүү (DeFi)	Энгийн банк бус үйлчилгээ, платформын уялдсан санхүүгийн загвар	Бие даасан хууль, олон улсын зохицуулалт, кибер аюулгүй байдлын зайлшгүй шаардлага

2.2. ФИНТЕКИЙН САЛБАРЫН ГОЛЛОХ ЧИГ ХАНДЛАГА

Банк санхүү, төлбөр тооцооноос эхлээд зээл олгох, хөрөнгө оруулалт, даатгал, зохицуулалтын технологи хүртэл финтек нь бидний санхүүгийн үйлчилгээтэй хэрхэн харьцах хэлбэрийг өөрчилсөөр байна. Финтекийн голлох сегментийг авч үзвэл:

- Цахим төлбөр тооцоо, мобайл төлбөр болон төлбөрийн системийг технологид суурилан санал болгодог үйлчилгээ (Payments as a Service (PaaS));
- Уламжлалт банкны үйлчилгээг API болон технологийн платформууд дамжуулан гуравдагч этгээдэд санал болгодог шийдэл (Banking as a Service (BaaS));
- Даатгалын бүтээгдэхүүн, эрсдэлийн үнэлгээ, нөхөн төлбөрийн процессыг автоматжуулах технологи (Insurtech as a Service (IaaS));
- Санхүүгийн байгууллагын зохицуулалтын шаардлагыг хангах, комплаенс болон эрсдэлийн хяналтыг технологийн тусламжтайгаар шийдэх (RegTech as a Service (RaaS));
- Санхүүгийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах технологиуд (Cybersecurity);
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн төлөвлөлт, автомат зөвлөх үйлчилгээ (robo-advisor) зэрэг хувийн санхүүгийн менежментийг сайжруулах технологи (Wealthtech as a Service (WaaS));
- Ил тод байдал, өгөгдлийн найдвартай

хадгалалт, криптовалюта зэрэг шинэчлэл авчирч буй хуваарилсан бүртгэлийн технологи.

Сүүлийн арван жилд технологийн дэвшил нь санхүүгийн салбарын бүхий л хэсэгт нэвтэрч, уламжлалт тоглогчдын бизнесийн загвар, хэрэглэгчтэй харилцах арга хэлбэрийг өөрчилж байна. Үүний үр дүнд санхүүгийн шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүнүүд бий болж, хууль, эрх зүйн зохицуулалтын шинэ шаардлага үүсэх болсон.

Финтек нь анх төлбөрийн систем болон мөнгөн гүйлгээний үйлчилгээний салбарт хүчтэй нэвтэрч эхэлсэн. Цахим төлбөр, мобайл төлбөр, peer-to-peer (P2P) төлбөрийн платформууд хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээтэй харьцах арга барилыг эрс өөрчилсөн. Үүний жишээнд PayPal, Square, Alipay, Kakao Pay зэрэг платформууд багтдаг. Энэ нь банкны харилцагчийн дунд шууд гүйлгээ хийх боломжийг бүрдүүлж, уламжлалт банкны зуучлагчийн үүргийг багасгасан.

Дараагийн шатанд зээлийн үйлчилгээний салбарт финтек эрчимтэй нэвтэрсэн. Финтект суурилсан зээлийн платформууд (жишээлбэл: LendingClub, Kiva зэрэг) нь уламжлалт банкнаас зээл авах боломжгүй хэрэглэгчдэд зориулсан шинэ төрлийн зээлийн сувгийг бий болгосон. Эдгээр платформууд нь өгөгдөлд суурилсан онооны систем, хиймэл оюун ухаанд түшиглэсэн эрсдэлийн үнэлгээг ашиглаж эхэлсэн.

Хүснэгт 2. Финтекийн голлох сегментүүд

Чиглэл	Үйлчилгээний төрөл	Зохицуулалтын гол асуудал
Цахим төлбөр ба гүйлгээ	Мөнгөн гүйлгээ, цахим хэтэвч, мобайл төлбөр, QR кодоор төлбөр хийх	Төлбөрийн системийн зөвшөөрөл, мөнгө угаахтай тэмцэх
Зээл ба зээлийн платформ	Хүн хоорондын зээл (peer-to-peer), зээлийн үнэлгээ, автомат батлах	Зээлийн лиценз, зээлийн эрсдэлийн хяналт
Хөрөнгө оруулалт ба хиймэл зөвлөх	Автомат хөрөнгө оруулалт, хөрөнгө удирдах платформ, жижиг хөрөнгө оруулагчдад зориулсан үйлчилгээ	Үнэт цаасны зохицуулалт, хөрөнгө оруулалтын зөвшөөрөл
Хамтын санхүүжилт (краудфандинг)	Хандивт суурилсан, зээлд суурилсан, хувьцаанд суурилсан санхүүжилт	Хөрөнгө оруулалтын эрсдэл, үнэн зөв мэдээлэл түгээх
Даатгалын технологи (InsurTech)	Онлайн даатгал, автомат нөхөн төлбөр, хиймэл оюунд суурилсан эрсдэлийн үнэлгээ	Даатгалын тусгай зөвшөөрөл, эрсдэлийн сан бүрдүүлэлт
Хувийн санхүүгийн менежмент	Орлого-зарлагын шинжилгээ, хуримтлалын төлөвлөгөө, санхүүгийн зөвлөгөө	Хувийн мэдээллийн хамгаалалт, хэрэглэгчийн итгэл
Нээлттэй санхүү (open banking)	Банкнүүдын мэдээллийг гуравдагч этгээдэд API-р дамжуулах	Өгөгдөлд хандах зөвшөөрөл, мэдээлэл хамгаалалт
Криптовалют ба дижитал хөрөнгө	Дижитал мөнгө, токен, хөрөнгө оруулалт, арилжаа	Зах зээлийн эрсдэл, мөнгө угаах, тусгай хууль хэрэгтэй
Төвлөрөлгүй санхүү (DeFi)	Гуравдагч этгээдгүйгээр хийгддэг гэрээт үйлчилгээнүүд	Хяналтгүй орчны эрсдэл, хэрэглэгчийн хамгаалалт
Бизнес-байгууллагын шийдэл	Нягтлан бодох бүртгэл, тооцооллын программ, гүйлгээний дотоод систем	Нягтлан бодох, татвар, ил тод байдалтай холбоотой шаардлага

2.3. ФИНТЕКИЙН САЛБАРТ АШИГЛАГДАЖ БҮЙ ТЕХНОЛОГИУД

Финтекийн салбарын хурдацтай хөгжил нь технологийн дэвшилтэй шууд холбоотой бөгөөд санхүүгийн үйлчилгээний хүртээмж, аюулгүй байдал, зардлын оновчлол, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахад чиглэсэн шинэ шийдлүүдийг бий болгож

байна. Олон улсын судалгаагаар дараах голлох технологиуд финтекийн үйл ажиллагааны суурь болж байна (Gomber et al., 2018; Zetzsche et al., 2017; IMF, 2019). Үүнд:

- Хиймэл оюун ухаан ба машин

- сургалт: Хиймэл оюун ухаан (artificial intelligence) болон машин сургалтын аргууд нь финтекийн салбарт зээлийн эрсдэлийг тооцоолох, хэрэглэгчийн зан төлөвийг шинжлэх, санхүүгийн залиланг илрүүлэх, автомат зөвлөмж өгөх зэрэгт өргөн хэрэглэгдэж байна. Эдгээр систем нь уламжлалт банкны шийдвэр гаргалтыг хурдасгаж, зардлыг бууруулах өндөр үр ашигтай (Gai et al., 2018).
- Блокчэйн технологи (blockchain): Блокчэйн технологи нь төвлөрсөн бус, ил тод бүртгэлийн систем бий болгох боломжтой бөгөөд криптовалюта, ухаалаг гэрээ, дижитал хөрөнгө зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүний суурь технологи болсон. Энэ технологи нь гүйлгээг шууд баталгаажуулах, зуучлагчгүйгээр хэрэгжүүлэх боломжийг олгож байна (Catalini & Gans, 2016).
 - Нээлттэй программ хангамжийн холболт (API): Нээлттэй API (application programming interface) нь банкууд болон гуравдагч этгээдүүдийн хооронд өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлж, хэрэглэгчийн зөвшөөрлөөр банкны мэдээллийг ашиглан шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх суурийг тавьж байна. Үүний үр дүнд нээлттэй санхүү (open banking) гэсэн ойлголт олон улсад төлөвшсөн (Zetzsche et al., 2020).
 - Өгөгдлийн дүн шинжилгээ (big data analytics): Финтек үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн зан төлөв, зээлжих чадвар, орлого-зарлага зэргийг бодит хугацаанд шинжлэх замаар автомат шийдвэр гаргах, зах зээлийн эрэлт хэрэгцээг урьдчилан тооцоолох, маркетингийн стратеги боловсруулах зэрэгт ашиглаж байна (Gomber et al., 2018).
 - Үүлэн тооцоолол (cloud computing): Үүлэн технологи нь финтекийн үйлчилгээний найдвартай ажиллагаа, мэдээлэл хадгалалт, уян хатан байдлыг нэмэгдүүлж, программ хангамжийг хэрэглэгчдэд илүү хурдан, хямд хүргэх боломжийг олгож байна (World Bank, 2020).
 - Кибер аюулгүй байдлын технологи: Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах, гүйлгээний найдвартай байдлыг хангах үүднээс биометр баталгаажуулалт, олон шатлалт нэвтрэлт, өгөгдөл шифрлэх зэрэг аюулгүй байдлын технологиуд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зохицуулалтын шаардлагад нийцэх үндэс болдог (IMF, 2019).
- Эдгээр технологи нь финтекийн хөгжлийн хөдөлгүүр болж, уламжлалт санхүүгийн тогтолцооны орон зайг дахин тодорхойлох, зохицуулалтын шинэ шаардлага бий болгох үндэс болж байна. Иймээс финтекийн үйл ажиллагааг зөв ойлгож, эрх зүйн орчныг технологийн түвшинтэй уялдуулах нь зайлшгүй шаардлагатай болж байна.

2.4. ФИНТЕКИЙН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ СОРИЛТ, БОЛОМЖ

Финтекийг эрх зүйн хувьд хэрхэн тодорхойлох талаар улс орнуудын хандлага харилцан адилгүй байна. Зарим орнууд (жишээлбэл, Их Британи, Япон, Европын Холбоо) финтекийг санхүүгийн салбарын дотоод шинэчлэл гэж үзэн одоогийн санхүүгийн хуулиудын хүрээнд зохицуулдаг бол бусад орнууд (жишээлбэл, Мексик, Казахстан, БНСУ) тусгай хууль тогтоомж баталж, бие даасан салбарын статустай болгон авч үзэж байна (Zetzsche et al., 2017; Buckley et al., 2021). Иймд дэлхийн түвшинд финтекийг “санхүүгийн салбарын дотоод дижитал хувьсгал” гэхээс гадна “шинэ төрлийн санхүүгийн экосистем” гэж үзэх хосолмол хандлага давамгайлж байгаа бөгөөд энэ нь улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо, бодлогын чиглэлээс хамаарч өөр өөрөөр хэрэгжиж байна.

2015 онд Хятадын Ezubao нэртэй P2P зээлийн платформ нь 7.6 тэрбум ам.долларын понзи схемийг хэрэгжүүлж, 900,000 гаруй хөрөнгө оруулагчийг хохироосон. Энэ хэрэг нь Хятадын финтекийн зохицуулалтын сул талыг илчилж, эрх баригчдыг P2P зээлийн салбарт хатуу зохицуулалт хийхэд хүргэсэн. Үүний үр дүнд, олон P2P платформууд хаагдаж, хөрөнгө оруулагчдын итгэл буурсан.

Их Британи нь финтекийн салбарт тэргүүлэгч орнуудын нэг байсан ч нээлттэй банкны хэрэгжилтэд зарим бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, хэрэглэгчдийн мэдлэгийн хомсдол, итгэлцлийн дутагдал, одоогийн картын төлбөрийн системийн хялбар байдал

зэрэг нь шинэ технологийн нэвтрэлтийг саатуулж байна. Үүний үр дүнд, олон финтек компаниуд ашиггүй ажиллаж, зарим нь ажилтнуудаа цомхотгох хүртэл арга хэмжээ авч байна. Засгийн газар зохицуулалтын шинэчлэл хийхээр зорьж байгаа ч банкны салбарын хөрөнгө оруулалтын идэвхгүй байдал нь шинэчлэлийн хурдыг удаашруулж байна. Дэлхийн финтекийн салбарт зохицуулалтын тодорхойгүй байдал, хууль эрх зүйн сорилтууд нь инновацыг саатуулж, хэрэглэгчдийн итгэлцлийг бууруулах эрсдэлийг хүлээсээр байна.

Зохицуулалтын хэрэгцээ, шаардлага:

- Зохицуулалтын асуудлууд: Санхүүгийн салбарын зохицуулалт нь хурдтай хөгжиж буй технологийн дэвшилтэй нийцэхгүй байх тохиолдол их байгаа бөгөөд финтекийн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль эрх зүйн зохицуулалт дутагдалтай байна.
- Аюулгүй байдал: Санхүүгийн мэдээллийн хамгаалалт, кибер аюулгүй байдал нь хамгийн чухал асуудал болдог.
- Эрсдэл болон хэрэглэгчийн итгэл: Блокчэйн болон криптовалют зэрэг шинэ технологиудад хэрэглэгчид итгэлгүй байдаг. Үүнээс гадна эдгээр технологиуд нь эрсдэл үүсгэж болзошгүй.
- Өрсөлдөөн: Финтек салбар нь уламжлалт банкны систем болон шинэ технологийн компаниудын хооронд өрсөлдөөнтэй тулгарч байгаа бөгөөд зохицуулалт нь зарим тохиолдолд өөдрөг биш байж болзошгүй.

III. УЛС ОРНУУДЫН ФИНТЕКИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сүүлийн арван жилд финтекийн дэвшил нь дэлхийн санхүүгийн зах зээл, зохицуулагч байгууллагууд болон хууль тогтоогчдын анхаарлыг татаж, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагыг бий болгосон томоохон өөрчлөлтийн эх үүсвэр болсон. Финтекийн үйлчилгээ нь уламжлалт банк, даатгал, хөрөнгө оруулалт, төлбөрийн системүүдийг орлох буюу нөхөх боломжтой, илүү хүртээмжтэй, дижитал хувилбараар санал болгодог болсон нь хууль эрх зүйн орчныг шинэчлэх бодит үндэслэл болж байна (Arner, Barberis & Buckley, 2017).

Улс орнууд энэхүү шинэ технологийн үзэгдэлд хариу өгөхдөө нийтлэг хэд хэдэн зарчим баримталж байгаа боловч тэдгээрийн эрх зүйн бүтэц, зохицуулалтын механизм, стратегиуд нь харилцан адилгүй байна. Финтек зохицуулалтын нийтлэг зарчимд дараах гол ойлголтууд багтдаг. Үүнд: эрсдэлд суурилсан зохицуулалт (risk-based approach), технологид саад учруулахгүй, инновацыг дэмжсэн уян хатан орчин бүрдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, өрсөлдөөнийг дэмжих, өгөгдөл хамгаалах болон цахим аюулгүй байдлыг хангах бодлого орно. Гэсэн хэдий ч эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх арга барил нь тухайн орны институтийн чадавх, зах зээлийн хөгжлийн түвшин, эрх зүйн тогтолцооноос шалтгаалан ялгаатай байдаг (Zetzsche et al.,

2017).

Зарим улс орнууд (жишээлбэл, Мексик, Бүгд Найрамдах Солонгос Улс, Арабын Нэгдсэн Эмират, Казахстан) финтекийн зах зээлийг зохицуулах зорилгоор тусгай нэгдсэн хууль буюу эрх зүйн цогц хүрээг боловсруулсан байдаг. Харин Их Британи, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Канад, Энэтхэг зэрэг орнууд нь олон хууль, дүрэм, салбарын зохицуулагчдын үүрэг хуваарьт суурилсан хуваагдсан зохицуулалтын тогтолцоог баримталдаг (Allen, 2019; Buckley et al., 2021). Нэгдсэн хуультай орнууд нь эрх зүйн тодорхой байдлыг хангаж, бизнесийн орчны тогтвортой байдал, эрх зүйн итгэлцлийг бүрдүүлэхэд дөхөмтэй гэж үздэг. Харин олон эх үүсвэр бүхий зохицуулалт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог, эрсдэлийн түвшинд тохирсон нарийвчилсан зохицуулалт хийх боломжийг олгодог гэж судлаачид тэмдэглэж байна.

Түүнчлэн финтек инновацыг дэмжсэн зохицуулалтын нэг арга хэрэгсэл нь сэндбокс зохицуулалтын орчин юм. Энэ тогтолцоо нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг тодорхой нөхцөл, хугацаанд бодит орчинд турших боломжийг олгодог бөгөөд зохицуулагчтай байнгын харилцаанд тулгуурласан уян хатан хяналтыг агуулдаг. Сэндбокс зохицуулалтыг анх 2016 онд Их Британийн Санхүүгийн зохицуулах хороо нэвтрүүлсэн бөгөөд түүнээс хойш Сингапур,

Австрали, Канад, Казахстан зэрэг олон улс ижил загвараар хөгжүүлсэн байдаг (Jenik & Lauer, 2017). Хэрэв энэхүү механизм нь хууль ёсны үндэслэлтэй, журам, шалгуур үзүүлэлт бүхий бүтэцтэй хэрэгжвэл финтекийн хөгжилд чухал хувь нэмэр үзүүлдэг болох нь харагдаж байна (Pasti et al., 2020). Зарим улс зөвхөн сэндбокс зохицуулалтын орчноор хязгаарлагдахгүй, мөн инновацын төв (innovation hub), зохицуулалтын зөвлөгөөний нэгж (regulatory guidance unit) зэрэг дэмжих механизмуудыг ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар Кэмбридж Суптекийн лабд бүртгэлтэй 67 идэвхтэй инновацын оффис, 75 зохицуулалтын сэндбокс хэрэгжиж буй бол Австралийн Үнэт цаасны хорооны сэндбокс, Малтагийн криптовалютын сэндбокс, Бразилын Үнэт цаасны хорооны сэндбокс үйл ажиллагаагаа зогсоосон байна (Cambridge Suptech Lab, 2025).

Улс орны туршлагаас харахад, Сингапур нь ил тод, олон талт оролцоог хангасан бодлого боловсруулалтын арга барилаар ялгардаг. Тус улсын төв банк финтекийг дэмжих зорилгоор тусгай төв байгуулж, салбарын тусгай зөвшөөрөл, зохицуулалтын орчны туршилт, нээлттэй программчлалын интерфэйс (API) зэрэг шинэчлэлийг зэрэгцүүлэн хэрэгжүүлсэн (MAS, 2022). Харин Казахстан улс Астана Олон Улсын Санхүүгийн Төвийн хүрээнд олон улсын эрх зүйн суурьтай зохицуулалтын орчны туршилтыг амжилттай нэвтрүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, финтек инновацыг дэмжих бодлого хэрэгжүүлж байна (AFSA, 2023). АНУ болон Европын Холбоо нь өөр өөр муж, бүс нутгийн онцлогт тулгуурласан олон шатлалт зохицуулалттай бөгөөд зарим тохиолдолд зохицуулалтын орчны туршилтыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлдэг.

3.1. БҮС НУТГИЙН ФИНТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.1. Европын холбоо болон Европын бүсийн орнууд

Европын холбоо (ЕХ)–ны хүрээнд финтекийн зохицуулалтыг нийтлэг дотоод зах зээлийн зарчмын дагуу хэрэгжүүлдэг олон шатлалт эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн. ЕХ нь 2020 онд баталсан «Цахим санхүүгийн стратеги» болон «Дижитал санхүүгийн бодлогын багц» (Digital Finance Package)–аараа дамжуулан финтек, хиймэл оюун ухаан, блокчейн технологи, криптовалют зэрэг шинэ технологийн хөгжилд хариу

үзүүлэх эрх зүйн суурийг тавьсан (European Commission, 2020). Үүнд багтсан гол баримт бичгүүдэд «Крипто хөрөнгийн зах зээлийг зохицуулах тухай журам» (MiCA), «Цахим төлбөрийн үйлчилгээний шинэчлэл» (PSD2 ба удахгүй PSD3), мөн «Өгөгдлийн хандалт, нээлттэй санхүүгийн журам» зэрэг орно. ЕХ нь нэгдсэн эрх зүйн хүрээг тодорхойлсон ч гишүүн орнууд өөрийн хууль тогтоомжийг боловсруулж, зарим нь бие даасан сэндбокс зохицуулалт, түр зөвшөөрөл, инновацын тусгай зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлээд байна (Zetsche et al., 2020).

3.1.2. Ази, Номхон далайн бүс

Ази, Номхон далайн бүс нутагт (АРАС) финтекийн зохицуулалт нь инновацад нээлттэй, технологийн дэвшлийг дэмжсэн чиглэлд хөгжиж байна. Сингапур нь салбар дундын зохицуулалтын механизмыг ашигладаг бөгөөд Сингапурын төв банк (Monetary Authority of Singapore) нь финтек болон дижитал санхүүг хөгжүүлэх зорилгоор “Финтек инновацийн групп”-ийг байгуулж, туршилтын орчны зохицуулалт (sandbox), API стандарт, зөвшөөрлийн системийн шинэчлэл, хэрэглэгчийн өгөгдлийн хамгаалалт зэрэг бодлогыг хэрэгжүүлдэг (MAS, 2022). БНСУ нь 2019 онд батлагдсан “Шинэлэг санхүүгийн үйлчилгээний тухай хууль”-ийн дагуу туршилтын орчныг хуульчилж, сэндрбоксын дараах үеийн тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн механизмыг бий болгосон (FSC Korea, 2021). Япон Улс нь «Финтекийн алсын хараа» баримт бичиг боловсруулж, лицензийн шаардлагыг зөөлрүүлэх, мэдээлэл солилцох тогтолцоог уян хатан зохицуулах бодлогыг баримталж байна (FSA Japan, 2021). Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) нь технологийн хурдыг хянахын зэрэгцээ төв банкны оролцоог нэмэгдүүлэн, бүсчилсэн туршилтын бүс, криптовалютын төрийн зохицуулалт бүхий арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүлж байна (PBOC, 2021).

3.1.3. Хойд Америк ба Латин Америкийн орнууд

Хойд Америкийн хувьд АНУ нь холбооны төв болон мужийн түвшинд хуваагдсан

зохицуулалтын тогтолцоотой. Холбооны түвшинд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах товчоо (CFPB), Үндэсний банкны хяналтын газар (OCC), Холбооны нөөцийн систем (Federal Reserve) зэрэг байгууллага финтекийн зарим үйл ажиллагааг зохицуулж, Үндэсний банкны хяналтын газар нь 2018 онд «Тусгай зориулалтын финтек лиценз» санал болгосон (OCC, 2018). Канад нь муж бүрийн хяналтын байгууллагатай хэдий ч Канадын үнэт цаасны зах зээлийн албад (CSA)-аар дамжуулан хамтарсан финтек стратеги боловсруулж байна (CSA, 2021).

Латин Америкийн бүс нутагт Мексик улс нь 2018 онд батлагдсан “Финтекийн хууль”-аар (Ley para Regular las Instituciones de Tecnología Financiera) финтек үйл ажиллагааг төвлөрсөн нэг хуулиар зохицуулсан цөөн орны нэг юм. Энэхүү хуульд цахим мөнгө, хамтын санхүүжилт, цахим зээл, өгөгдлийн нээлттэй солилцоо, зохицуулалтын орчны туршилтын заалтууд тусгагдсан бөгөөд цаашлаад пост-сэндбокс лиценз олгох нөхцөл бүрдсэн (Arner et al., 2020). Бразил улс нь Төв банк, Санхүүгийн үйлчилгээний хяналтын агентлаг (CVM), өрсөлдөөний газар (CADE)-ын хамтарсан финтек стратеги хэрэгжүүлж, нээлттэй санхүү, дижитал банкны зохицуулалт, инновацын зохицуулалтын платформуудыг ажиллуулж байна (Banco Central do Brasil, 2021).

3.1.4. Зүүн Европ болон Төв Азийн бүс

Казахстан улс нь Астана Олон Улсын Санхүүгийн Төв (AIFC)-ийн хүрээнд финтек үйлчилгээний туршилт, зохицуулалтын

шинэлэг тогтолцоог хэрэгжүүлж байна. Тус төв нь олон улсын хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, итгэл төрүүлэхүйц эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс Английн иргэний эрх зүйн тогтолцоог үндэслэн сэндрбокс буюу туршилтын зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлж байна. Туршилтын хугацаанд зохицуулагч байгууллагаас шууд хяналт тавихын зэрэгцээ шинэ үйлчилгээний хууль эрх зүйн үр нөлөөг үнэлж, амжилттай бол бүрэн зохицуулалтын хүрээнд шилжүүлдэг шаталсан механизмтай (AFSA, 2023). Түүнчлэн Астана Олон Улсын санхүүгийн төв нь крипто хөрөнгийн үйлчилгээ, ухаалаг гэрээ, дижитал хэтэвч зэрэг бүтээгдэхүүнийг зохицуулах тодорхой журам боловсруулсан бөгөөд Үндэсний Банк, Санхүүгийн зах зээлийн зохицуулах хороотой хамтран шинэ хууль, журамд туршилтын дүнг тусган хөгжүүлж байна. Гүрж, Армен зэрэг улс орнууд мөн финтек хөгжлийг дэмжих зорилгоор цахим мөнгө, цахим зээлийн үйлчилгээний зохицуулалтыг боловсруулж, төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байна.

Монгол Улсын хувьд 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, СЗХ-ны дэргэд сэндрбокс зохицуулалтын албыг байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үүний дагуу “Сэндрбокс зохицуулалтын орчны журам”-ыг батлан хэрэгжүүлж, туршилтын орчныг цахим зээл, төлбөр тооцоо, блокчэйнд суурилсан үйлчилгээ зэрэг чиглэлээр хэрэгжүүлж эхлээд байна (FRC Mongolia, 2023). Үүнээс гадна Монголбанкнаас нээлттэй санхүү,

хиймэл оюун, инновацын оффис зэрэг чиглэлээр бодлогын түвшинд судалгаа, стандартын төсөл боловсруулж эхэлсэн.

3.1.5. Африк болон Ойрх Дорнодын бүс

Бахрейн нь Ойрх Дорнодын бүсэд хамгийн идэвхтэй финтек зохицуулалт хөгжүүлсэн улс бөгөөд Төв банк нь “FinHub 973” платформыг ажиллуулж, сэндрбокс зохицуулалт, түр зөвшөөрөл, инновацын тусгай зөвшөөрлийн системийг нэвтрүүлсэн (СВВ, 2022). Бахрейн нь мөн пост-сэндрбокс хяналт, дижитал банкны тусгай эрх зүйн орчныг хөгжүүлэн олон улсын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн нээлттэй бодлого баримталж байна. Арабын Нэгдсэн Эмират улс нь Абу Даби болон Дубайн санхүүгийн чөлөөт бүсүүдэд (ADGM, DIFC) финтекийн зориулалтын хууль, зохицуулалтын механизм бүхий сэндрбокс, инновацын төвүүдийг амжилттай ажиллуулж байгаа бөгөөд дижитал хөрөнгийн үйлчилгээ, төлбөрийн платформ, зохицуулалтын технологи (RegTech), даатгалын технологи (InsurTech) зэрэг төрөлжсөн зохицуулалтыг бий болгожээ (ADGM, 2023).

Харин Кени, Өмнөд Африк зэрэг Африкийн орнууд сүүлийн жилүүдэд финтек бүтээгдэхүүний туршилт, цахим төлбөрийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зохицуулалтын технологийн платформыг хэрэгжүүлэх шатандаа явж байгаа бөгөөд энэ бүс нутагт финтекийн зохицуулалт эрчимтэй тэлж байна. Өмнөд Африк нь Үндэсний банк, Санхүүгийн зохицуулах газар, Өрсөлдөөний хороо зэрэг байгууллагын хамтарсан

дигитал санхүүгийн зохицуулалтын төсөл боловсруулж, үндэсний сэндбокс системийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна (IFWG South Africa, 2022). Руанда болон Гана зэрэг улс орнууд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

зорилгоор мобайл мөнгө, цахим хэтэвч, хиймэл оюун, нээлттэй API зэрэг технологийн шийдлийг туршин, зохицуулалтын түвшинд шилжүүлэх бодлогын суурь тавьж байна (World Bank, 2021).

Хүснэгт 3. Бүс нутгийн финтекийн эрх зүйн зохицуулалт, бодлогын чиг хандлага

Бүс нутаг	Зохицуулалтын хандлага	Онцлог зохицуулалт / бодлого
Европын бүс	Олон шатлалт, нийтлэг зах зээлийн зарчимд суурилсан	Крипто хөрөнгийн журам, цахим төлбөрийн шинэчлэл
Ази, Номхон далайн бүс	Уян хатан, технологид нийцсэн, төр-хувийн хамтарсан дэмжлэг	Шинэлэг үйлчилгээний хууль (БНСУ), стратеги, туршилтын бүс
Хойд ба Латин Америк	Холбооны ба бүс нутгийн хуваагдсан зохицуулалт	Финтекийн тусгай хууль (Мексик), лицензийн тогтолцоо
Зүүн Европ ба Төв Ази	Туршилт, шаталсан зөвшөөрөл, олон улсын хуулийн суурь	Сэндбокс (Казахстан, Монгол), цахим мөнгө, зээлийн зохицуулалт
Африк ба Ойрх Дорнод	Санхүүгийн хүртээмж, шинэлэг шийдлийг дэмжсэн туршилт	Түр зөвшөөрөл, мобайл мөнгө, дигитал банкны эрх зүй

3.2. УЛС ОРНУУДЫН ФИНТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.2.1. Мексик Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Мексик улс нь 2018 онд батлагдсан “Финтек хуулиар” (Ley para Regular las Instituciones de Tecnología Financiera) финтекийн үйл ажиллагааг төвлөрсөн нэг эрх зүйн хүрээнд зохицуулсан дэлхийн анхны улсуудын нэг юм. Энэхүү хууль нь цахим мөнгө, хамтын санхүүжилт (олон нийтийн хөрөнгө оруулалт), өгөгдлийн нээлттэй солилцоо, цахим зээл, технологид суурилсан санхүүгийн байгууллагуудын зөвшөөрөл, хяналт, хэрэглэгчийн мэдээлэл хамгаалалт зэрэг зохицуулалтыг хамарсан.

Түүнчлэн хуульд “туршилтын орчин” буюу сэндбокс зохицуулалтыг хуульчилж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхой нөхцөлтэйгөөр хязгаарлагдмал хүрээнд турших, улмаар амжилттай бол шууд тусгай зөвшөөрөл авах боломжийг нээсэн.

Финтекийн энэ хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд нь төв банк (Banco de México), Санхүүгийн зах зээлийн Үндэсний комисс (CNBV), Хэрэглэгчийн санхүүгийн хамгааллын үндэсний комисс (CONDUSEF) зэрэг олон институтийн оролцоотой байдлаар зохион байгуулагдсан. Эдгээр

байгууллагууд нь хамтран ажиллаж, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийн түвшнийг тодорхойлон, зөвшөөрөл олгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах үүрэгтэй. Зохицуулалтын хандлага нь эрсдэлд суурилсан, үйл ажиллагааны ангилалд тулгуурласан бөгөөд технологийн дэвшлийг хязгаарлахгүй, нээлттэй байдлыг хадгалах бодлогыг баримталсан.

Зохицуулагч байгууллагуудын хариуцсан чиг үүрэг:

- Санхүүгийн зах зээлийн үндэсний комисс – Тусгай зөвшөөрөл олгох, хяналт хэрэгжүүлэх, тайлан шалгах;
- Мексикийн Төв банк – Төлбөрийн систем, тогтвортой байдал, дижитал мөнгөний зохицуулалт;
- Хэрэглэгчийн санхүүгийн хамгааллын үндэсний комисс – Хэрэглэгчийн эрх, гомдлын зохицуулалт, мэдээлэл хамгаалалт;

Хууль нь нийт 8 бүлэг болон 145 зүйлтэй бөгөөд финтекийн үйл ажиллагааг эрх зүйн хувьд тодорхой ангилж, бүтэц, шалгуур, хяналтын механизмыг иж бүрнээр хуульчилсан. Хуулийн хамрах хүрээнд дараах үндсэн байгууллагын ангилал болон бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зохицуулна:

Байгууллагын үндсэн ангилал:

- Хамтын санхүүжилтийн байгууллага (Instituciones de Financiamiento Colectivo);
- Цахим мөнгөний санхүүгийн байгууллага (Instituciones de Fondos

de Pago Electrynico);

- Технологид суурилсан үйлчилгээ үзүүлэгч байгууллага (Articulo 76);

Зохицуулалттай бүтээгдэхүүн, үйлчилгээ:

- Цахим мөнгө;
- Хамтын санхүүжилт (краудфандинг);
- Цахим төлбөрийн систем;
- Цахим зээл;
- Нээлттэй өгөгдлийн платформ (API);
- Тоон хэтэвч;
- Хэрэглэгчийн мэдээлэл солилцоо;
- Гадаадын финтек үйлчилгээ үзүүлэгчийн оролцоо;
- Дижитал хөрөнгө, тоон гэрээ;
- Шаардлагын ангилал.

Байгууллагын түвшинд тусгай зөвшөөрөл авах, хяналт шалгалтад хамрагдах, аудитын шаардлага, нөөц хөрөнгийн доод хэмжээ, дотоод хяналтын тогтолцоо зэрэгт хяналт, зохицуулалт хэрэгжүүлэхэд чиглэсэн бол бүтээгдэхүүн, үйлчилгээний түвшинд өгөгдөл хамгаалалт, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн зөвшөөрөл, мэдээллийн ил тод байдал зэргийг зохицуулахад чиглэсэн.

Сэндбоксын дараах зохицуулалт: Мексикийн финтекийн хууль нь технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг тусгайлан зохицуулахын зэрэгцээ зах зээлд нэвтрэх шинэ бүтээгдэхүүнийг сайн дурын үндсэн дээр туршилтын орчин (сэндбокс)–д хамруулж, богино хугацаанд хяналттайгаар турших боломжийг олгодог. Энэ нь заавал дамжин гарах шат биш боловч өндөр эрсдэлтэй, шинэлэг технологи бүхий бүтээгдэхүүнд зориулсан дэд шатны

зохицуулалт болж ажилладаг. Сэндбоксыг зохицуулалт нь шууд зах зээлд гарах эрсдэлийг бууруулж, зохицуулагчтай харилцан ойлголцсон нөхцөлд эрх зүйн бүрэн зөвшөөрөлд шилжих боломжийг бүрдүүлдэг. Сэндбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомж эсхүл финтекийн хуулийн хүрээнд шаардлагатай зөвшөөрлийг аван үйл ажиллагаагаа явуулдаг.

3.2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

Хууль, эрх зүйн зохицуулалт: БНСУ нь олон салбарын хууль, зохицуулалтын хүрээнд финтекийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хамарч, зохицуулалтын хүрээг бий болгожээ. Үүнд дараах гол баримт бичгүүд багтана:

- “Санхүүгийн байгууллагын тухай хууль”–уламжлалт банк санхүүгийн үйл ажиллагааны үндсэн зохицуулалт;
- “Төлбөрийн үйлчилгээний тухай хууль”–дигитал төлбөр, цахим мөнгө, хэтэвч зэрэг үйлчилгээ;
- “Цахим мөнгөний журам”–цахим санхүүгийн бүтээгдэхүүний зохицуулалтын нарийвчилсан нөхцөл;
- “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”–хэрэглэгчийн өгөгдөл хамгаалалт, өгөгдөл солилцооны журам;
- “API ашиглалтын удирдамж”, “Мэдээлэл нээлттэй солилцох стандарт” гэх мэт бодлогын баримт бичгүүд.

Түүнчлэн 2019 онд “Шинэлэг санхүүгийн үйлчилгээний тухай хууль”–ийг баталсан

бөгөөд тус хууль нь сэндбоксын зохицуулалтын механизм болон инновацын дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болсон юм.

Зохицуулалтын хандлага нь дараах нийтлэг бодлогууд дээр тулгуурладаг:

- Эрсдэлд суурилсан хяналт болон пропорциональ зохицуулалт;
- Инновацад суурилсан дэмжлэг үзүүлэх уян хатан зохицуулалтын орчин;
- Технологийн дэвшлийг хязгаарлах–гүйгээр хууль, журамд үе шаттайгаар шинэчлэл хийх;
- Хэрэглэгчийн эрх ашгийг тэргүүнд тавих, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Нээлттэй санхүү, API стандартын бодлогоо өргөтгөх замаар финтекийн өрсөлдөөнийг дэмжих гэх мэт.

Эдгээр хандлагаар дамжуулан БНСУ нь финтекийн үйлчилгээний хууль ёсны орчныг бүрдүүлж, технологийн дэвшлийг бодлогын түвшинд тусгаж чадсан бөгөөд салбар хоорондын зохицуулалтыг ил тод, хамтарсан байдлаар шийдвэрлэх чиглэлийг баримталдаг.

БНСУ нь дараах төрлийн финтек үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хамарч зохицуулдаг. Үүнд:

- Цахим мөнгө, цахим төлбөрийн систем: “Төлбөрийн үйлчилгээний тухай хууль”, “Цахим мөнгөний журам”–д суурилсан зохицуулалт;
- Тоон хэтэвч, цахим зээл, хөрөнгө удирдлагын платформ: Санхүүгийн

байгууллагын хууль, үнэт цаасны зах зээлийн зохицуулалтад хамрагдана;

- Даатгалын технологи (InsurTech): Даатгалын тухай хуульд суурилсан цахим бодлого санал болгох үйлчилгээ;
- Өгөгдлийн нээлттэй солилцоо, API хэрэглээ: Санхүүгийн мэдээллийн стандартаар дамжуулан зохицуулдаг бөгөөд “API удирдамж” тусгайлан гаргасан (Financial Services Commission, 2022);
- Хувийн мэдээлэл хамгаалалт, өгөгдлийн зөвшөөрлийн удирдлага: “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-д үндэслэсэн зохицуулалт;
- Блокчэйд суурилсан үйлчилгээ, хиймэл оюунд суурилсан үнэлгээ, шийдвэрийн систем: технологийн туршилтаар дамжин сэндрбоксоод туршигдаж, зохицуулалттай хэлбэрт шилжиж буй бүлэгт багтдаг.

Финтекийн салбарт ашиглагдаж буй гол технологиуд (жишээлбэл, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээ, блокчэйн, API зэрэг) болон үүн дээр суурилсан бүтээгдэхүүн (цахим төлбөр, зээл, тоон хэтэвч, хөрөнгө удирдлага, даатгалын автомат шийдэл гэх мэт)-ийг эрх зүйн зохицуулалтын хүрээнд оруулахын тулд БНСУ нь холбогдох байгууллагууд хоорондын уялдаатай, шаталсан зохицуулалтын арга барил баримталдаг.

Сэндрбоксын дараах зохицуулалт: “Шинэлэг санхүүгийн үйлчилгээний тухай хууль” нь сэндрбокс зохицуулалтыг хуульчилж,

өндөр эрсдэлтэй, шинэлэг бүтээгдэхүүнд зориулсан хязгаарлагдмал хугацаатай, нөхцөлт зохицуулалтын хүрээнд турших эрх олгодог. Ингэснээр компаниуд үйл ажиллагаагаа шууд зах зээлд турших боломжтой болохын зэрэгцээ зохицуулагчтай байнгын харилцаанд орж, хуульд суурилсан бүрэн зөвшөөрөл авах боломж нээгддэг. Мөн Санхүүгийн үйлчилгээний хорооноос “инновацийн дэмжлэг үзүүлэх төв”, “зохицуулалтын тайлбар өгөх нэгж” зэрэг байгууллагыг ажиллуулж, бодлогын болон практик түвшинд технологид суурилсан бизнесийг дэмжих нөхцөлийг бүрдүүлжээ.

Зохицуулалтын хандлага нь технологийн дэвшлийг сааруулалгүйгээр зохистой хяналт тогтоох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн. Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC) нь шинэ бүтээгдэхүүнд сэндрбокс эрх олгох шийдвэр гаргах, шалгуур тогтоох эрхтэй бол Санхүүгийн хяналтын алба (FSS) нь хэрэгжилт, тайлан, эрсдэлийн хяналт зэргийг хариуцан гүйцэтгэдэг. Мөн “Инновацийн зохицуулалтын төв” хэмээх тусгай нэгж нь сэндрбокс хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй.

Энэхүү хуулийн дагуу дараах чиглэлийн санхүүгийн үйлчилгээг сэндрбоксоор дамжуулан зохицуулалттай хэлбэрт шилжүүлэх боломжтой:

- Өгөгдөлд суурилсан зээл болон үнэлгээний систем;
- Тоон хэтэвч, цахим мөнгө, блокчэйд суурилсан төлбөрийн үйлчилгээ;

- API–д суурилсан өгөгдлийн нээлттэй солилцоо;
- Ухаалаг гэрээ, хиймэл оюунд суурилсан хөрөнгө удирдлага.

“Шинэлэг санхүүгийн үйлчилгээний тухай хууль” нь шинэ төрлийн үйлчилгээнд холбогдох зөвшөөрлийг нь өгөх, зохицуулалтын орчинд өөрчлөлт, шинэчлэлт оруулах үйл ажиллагааны гүүр болгож ашигладаг. Хэрэв сэндрбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчин тодорхой бол тухайн үйлчилгээ нь холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг авснаар үйл ажиллагаагаа эрхлэх бөгөөд Санхүүгийн үйлчилгээний хороо нь зөвшөөрөл авах хүсэлтийг хурдасгасан хэлбэрээр шийдвэрлэдэг. Харин зохицуулалтын орчинд өөрчлөлт орох шаардлагатай бол түр зөвшөөрөл олгох мөн “сэндбоксоос гарсан инновацлаг санхүүгийн үйлчилгээ” гэсэн нэршлийг олгох зохицуулалтыг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр нь сэндрбоксын хугацаа дууссан ч гэсэн шаардлагатай зохицуулалтын өөрчлөлт орох хүртэл үйл ажиллагаагаа явуулах боломжийг олгодог.

3.2.3. Казахстан Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Казахстан улс нь финтекийн үйл ажиллагааг Астана Олон Улсын Санхүүгийн Төв (AIFC)–ийн хүрээнд хэрэгжиж буй тусгай бүсийн зохицуулалтаар хэрэгжүүлж байна. Астана Олон Улсын санхүүгийн төв нь 2015 оны 12–р сарын 7–ны өдөр Ерөнхийлөгчийн №158 тоот зарлигаар байгуулагдсан бөгөөд 2018 оноос

албан ёсоор үйл ажиллагаа эхлүүлсэн. Энэхүү төв нь казахстаны үндэсний хуулиас тусдаа, английн иргэний эрх зүйн зарчимд тулгуурласан, олон улсын хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлдэг.

Астана Олон Улсын санхүүгийн төвийн хүрээнд дараах үндсэн баримт бичгүүд хэрэгждэг:

- “Астана Олон Улсын санхүүгийн төвийн тухай Үндсэн хууль” – төвийн бүтэц, зохион байгуулалт, зохицуулалтын зарчим;
- “Астана Олон Улсын санхүүгийн төвийн Санхүүгийн үйлчилгээний журам” – санхүүгийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, зөвшөөрөл, хяналтын журам;
- “Астана Олон Улсын санхүүгийн төвийн финтек журам” – финтек бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах сэндрбоксын туршилтад суурилсан зохицуулалт;
- Цахим төлбөрийн үйлчилгээний журам;
- Дижитал хөрөнгийн үйлчилгээний журам;
- Хамтын хөрөнгө оруулалтын цахим платформын журам.

Эдгээр баримт бичгийг Астана Санхүүгийн үйлчилгээний зохицуулах газраас баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг. Санхүүгийн үйлчилгээний зохицуулах газар нь дараах үндсэн үүргүүдийг гүйцэтгэдэг:

- Түр зөвшөөрөл олгох, шалгуур тогтоох;
- Туршилтын орчныг хэрэгжүүлэх (сэндрбокс);

- Бүрэн зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах;
- Хяналт, тайлагнал, эрсдэлийн үнэлгээ хийх;
- Зохицуулалтын хандлага нь;
- Инновацыг туршихад зориулсан түр зөвшөөрлийн тогтолцоо;
- Эрсдэлд суурилсан, технологид ээлтэй уян хатан хандлага;
- Хэрэглэгчийн мэдээлэл хамгаалалт, өгөгдлийн нууцлалд анхаарсан зохицуулалт;
- Олон улсын санхүүгийн стандартад нийцсэн эрх зүйн орчин бүрдүүлэх.

Сэндбоксын дараах зохицуулалт: Туршилтын орчныг «Финтекийн Лаб» хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд үүнд бүртгэгдсэн компаниуд Астана Санхүүгийн үйлчилгээний зохицуулах газрын англи эрх зүйд суурилсан нөхцөлөөр үйл ажиллагаагаа турших боломжтой байдаг. Астана Олон Улсын санхүүгийн төвийн зохицуулалт нэлээд хөнгөн, уян хатан байдаг. Тухайлбал Казакстан улс нь өөрсдийн үндэсний хуулиар крипто биржийн үйл ажиллагааг хориглодог бол Астана олон улсын санхүүгийн төвийн хүрээнд крипто биржийн үйл ажиллагааг зөвшөөрдөг. Сэндбоксын орчинд туршигдаж байх хугацаанд нь бүрэн хэмжээний зөвшөөрөл авахын тулд биелүүлэх ёстой шаардлага, шалгууруудыг боловсруулах ажлыг гүйцэтгэдэг. Түүнчлэн Астана санхүүгийн төвд Финтекийн тусгай зөвшөөрлийг олгодог бөгөөд тус зөвшөөрөл нь сэндбоксын зохицуулалтаас арай өргөн цар хүрээг хамарч болох бөгөөд

дийлэнх тохиолдолд тодорхой хэмжээний хязгаарлалтыг тавьдаг. Мөн хуулийн хүрээнд зохицуулалтын орчин хараахан бүрдээгүй ч зах зээлд нэвтрэхэд ямар нэг төрлийн саадгүй үйлчилгээнд “дэмжсэн бичиг (comfort letter)”, “хяналтын гэрээ” зэрэг баримт бичгийг гаргах тохиолдол байдаг бөгөөд ингэснээр шаардлагатай зохицуулалтын орчин бүрдэх хүртэл тухайн шинэ төрлийн үйл ажиллагаа саадгүй явагдах боломжийг олгодог.

3.2.4. Сингапур Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Сингапур улс нь финтекийн үйл ажиллагааг нэгдсэн бодлогын хүрээнд зохицуулдаг буюу Сингапурын Төв банкны тухай хуулиар (Monetary Authority of Singapore Act) тодорхойлогддог. Төв банк нь үндсэн хууль тогтоомж болох Санхүүгийн үйлчилгээний тухай хууль, Үнэт цаасны болон фьючерсийн тухай хууль, Цахим төлбөрийн үйлчилгээний тухай хууль зэрэг олон хуулийн уялдаатай байдлаар санхүүгийн салбарыг зохицуулдаг.

Сингапурын Төв банк нь “инновацыг хориглох бус, эрсдэлд суурилсан хандлага” – тайгаар финтекийн үйлчилгээг зохицуулдаг. Төлбөрийн үйлчилгээний тухай хууль (Payment Services Act, 2019) нь төлбөрийн төрөл бүрийн үйлчилгээ, криптовалют, цахим түрийвч зэрэг шинэ бүтээгдэхүүнд зориулсан ангилал, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг тодорхойлсон (MAS, 2020). Үүнээс гадна Сингапурын Төв банк нь “зөөлөн зохицуулалт” буюу удирдамж, зөвлөмж хэлбэрээр робо–зөвлөх үйлчилгээ, дижитал

токен санал болголт зэрэгт зориулсан зааварчилгааг гаргасан (MAS Guidelines on Digital Advisory Services, 2018; MAS Guide to Digital Token Offerings, 2020).

Сингапурын Төв банк нь дараах чиглэлүүдэд зохицуулалт хэрэгжүүлдэг:

- Тусгай зөвшөөрөл олгох (PSA-ийн хүрээнд);
- Туршилтын орчныг (sandbox) хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны ил тод байдал, эрсдэлийн ангилалд тулгуурласан хяналт;
- Хяналт, удирдамжийн механизм (regulatory guidance).
- Сингапур нь дараах төрлийн финтек бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулж байна:
 - QR код, NFC зэрэг технологид суурилсан мобайл төлбөр;
 - PayNow, FAST зэрэг дотоодын шуурхай мөнгөн гүйлгээний систем;
 - Цахим түрийвч, дижитал зээл, “одоо аваад дараа төл” систем;
 - Робо зөвлөх буюу хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө оруулалтын зөвлөгөө;
 - Криптовалют, токен санал болголт (ICO, STO);
 - Даатгалын технологи (InsurTech), ухаалаг гэрээ, блокчэйн платформууд (MAS, 2022).

Сэндбоксын дараах зохицуулалт: Сингапурын сэндбокс зохицуулалт нь аливаа төрлийн зохицуулалтын шаардлагаас хөнгөлөгдөх хэрэгсэл болдоггүй бөгөөд амжилттай

туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн хүсэлтээ бүх шаардлагыг нь хангасны үндсэн дээр гарган үйл ажиллагаагаа эрхэлдэг. Түүнчлэн Сингапурын төв банк нь шаталсан зохицуулалтыг хэрэгжүүлдэг бөгөөд том хэмжээний байгууллагуудад тавигддаг зохицуулалтын шаардлагууд нь нэлээдгүй өндөр байдаг бол дөнгөж эхэлж буй байгууллагуудын хувьд үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжих хүртэл харьцангуй бага шаардлагуудыг тавьдаг (Global Legal Insights, 2024). Зохицуулалтын энэхүү хэлбэр нь сэндбоксын зохицуулалтаас шилжих үйл явцыг илүү хялбар болгодог.

Хэрэв аль нэг зохицуулалтын салбарт хамруулах боломжгүй цоо шинэ төрлийн үйлчилгээ сэндбоксоод туршигдсан тохиолдолд шинэ төрлийн заавар, зөвлөмж гаргах эсхүл шаардлагатай хуулийн өөрчлөлтийг хийдэг. Мөн зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацаанд сэндбоксын хугацааг тусгай нөхцөлтэйгөөр сунгах эсхүл түр хугацааны зохицуулалт хэрэгжүүлэх байдлаар зохицуулах тохиолдлууд байдаг.

3.2.5. Япон Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Япон улс нь финтекийн салбарыг тусгай нэгтгэсэн хуулиар бус, харин санхүүгийн салбарын уламжлалт хуулиудын хүрээнд шаталсан байдлаар зохицуулж байна. Япон улсад финтекийн үйл ажиллагааг дараах үндсэн хууль, журмаар зохицуулдаг:

- Банкны тухай хууль–дижитал банк болон цахим санхүүгийн байгууллагуудын лиценз, үйл

ажиллагааны нөхцөл;

- Төлбөрийн үйлчилгээний тухай хууль–цахим төлбөр, цахим мөнгөн түрийвч, цахим шилжүүлгийн зохицуулалт;
- Мэдээлэл хамгаалах тухай хууль–хэрэглэгчийн өгөгдөл цуглуулах, хадгалах, ашиглах журам;
- Криптовалютын тухай хууль, журам–крипто биржүүд, хадгаламж, арилжаа зэрэг үйлчилгээнд тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт;
- Хөрөнгө оруулалтын үйлчилгээтэй холбоотой хууль–хөрөнгийн удирдлага, токен санал болголт, цахим биржийн үйлчилгээ.

Японд финтекийн салбарт хамаарах хууль, журам, зөвшөөрөл, хяналтыг дараах гол байгууллагууд хэрэгжүүлдэг. Үүнд:

- Японы Санхүүгийн Үйлчилгээний Газрын Ерөнхий Хороо–банкууд, даатгал, үнэт цаас, финтек байгууллагуудыг хянан зохицуулдаг гол байгууллага;
- Японы Төв банк–төлбөрийн систем, мөнгөний бодлого, дижитал иений туршилт хариуцдаг;
- Цахим харилцаа холбоо, мэдээллийн технологийн яам–өгөгдлийн хамгаалалт, цахим мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьдаг;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагууд–цахим төлбөр, зээл, хөрөнгө оруулалт зэрэгт хэрэглэгчийг хамгаалах үүрэгтэй.

Япон улс нь «Финтекийн алсын хараа» бодлогын баримт бичиг гарган, финтекийн

шинэ технологийг зохицуулах, дэмжих хүрээг тодорхойлсон. Тус бодлого нь инновацыг уян хатан зохицуулах, хэрэглэгчийн өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, технологи, банк хоорондын хамтын ажиллагааг дэмжих, API нээлттэй бодлогыг урамшуулах зорилготой.

Япон улсад дараах төрлийн финтек үйлчилгээ давамгайлж байна. Үүнд:

- Цахим мөнгөн түрийвч–гар утсаар төлбөр хийх системүүд (PayPay, Rakuten Pay, LINE Pay гэх мэт);
- Дижитал банк болон мобайл банкны үйлчилгээ–хэрэглэгчид цахимаар бүртгүүлж, банкны бүх төрлийн үйлчилгээ авах боломжтой;
- Цахим зээл, зээлийн онооны автомат үнэлгээ;
- Робо–зөвлөх үйлчилгээ–хөрөнгө оруулалтыг хиймэл оюун ухаанд суурилан удирдах системүүд;
- Криптовалютын бирж, арилжаа, блокчэйнд суурилсан хөрөнгийн платформ;
- Төлбөрийн интеграци системүүд–жижиглэн худалдаа, тээвэр, төрийн үйлчилгээтэй уялдсан нэгтгэсэн төлбөрийн шийдлүүд;
- Цахим төлбөр, цахим мөнгө;
- Краудфандинг, цахим зээл;
- Блокчэйнд суурилсан үйлчилгээ, криптовалют;
- API, нээлттэй өгөгдлийн хэрэглээ.
- Финтекийн үйлчилгээ нь Японд өндөр технологийн суурьтай, өгөгдөлд суурилсан, уламжлалт банкны тогтолцоотой зэрэгцэн хөгжиж байна.

Мөн криптовалютын үйлчилгээг хуулийн хүрээнд бүртгэлтэйгээр зохицуулдаг цөөн орнуудын нэг бөгөөд криптовалютын бирж, хадгаламж, арилжааны компаниудад тусгай зөвшөөрөл олгодог систем бүрдүүлсэн. Японы эрх баригчид нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө угаахтай тэмцэх, өгөгдлийн аюулгүй байдлыг хангахыг чухалчилдаг.

Сэндбоксын дараах зохицуулалт: Япон улс нь санхүүгийн үйлчилгээний шинэчлэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохицуулалтын зарим шинэ хандлагыг нэвтрүүлсэн бөгөөд үүнд шинэ төрлийн үйлчилгээ турших “зохицуулалтын туршилтын орчин” ч хамаарах ба сэндбокс туршилтын тогтолцоог 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Хэрэв сэндбоксын туршилт амжилттай болбол тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнд байнгын зөвшөөрлийг өгөх үүднээс зохицуулалтын заавар гаргах эсхүл холбогдох хууль, тогтоомждоо өөрчлөлт оруулдаг. Хэрэв төслийг арай илүү удаан хугацаанд турших хүсэлтэй бол сэндбоксын туршилтын хугацааг мөн сунгадаг. Гэхдээ шаардлагатай зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацаа их авах тохиолдолд амжилттай туршигдсан үйлчилгээг түр зогсоох эсхүл одоо хүчин төгөлдөр мөрдөж буй журмын хүрээнд үйл ажиллагаагаа тохируулан хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Мөн шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч буй утгатай захидал гаргах тохиолдол байдаг бөгөөд энэ нь байгууллагуудыг холбогдох хуулийн

шинэчлэл хийх хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг олгодог.

3.2.6. Филиппин Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Филиппин улс нь сүүлийн арван жилийн хугацаанд дижитал банк, цахим төлбөрийн систем, блокчэйн технологи зэргийг идэвхтэй нэвтрүүлж, финтекийн салбарт хүчтэй өрсөлдөгч болон гарч ирсэн хөгжиж буй орнуудын нэг юм. Улсын хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор финтекийн хөгжлийг төрийн бодлогоор дэмжин, ялангуяа банкны үйлчилгээ авч чаддаггүй иргэдийг хамруулах замаар дижитал эдийн засгийн өсөлтийг хангаж байна.

Цахим мөнгө, цахим хэтэвч, дижитал зээл, дижитал банк, жижиг хэмжээний хөрөнгө оруулалтын платформ зэрэг үйлчилгээний хэрэглээ огцом нэмэгдэж, Ковид-19 цар тахлын нөлөөгөөр цахим үйлчилгээнд шилжих хөдөлгөөн эрчимжсэн. Үүний үр дүнд цахим төлбөр, цахим зээлийн систем зэрэг нь өргөн хэрэглээний үйлчилгээ болж, финтек салбарын хөрөнгө оруулалт болон хэрэглэгчийн тоо тасралтгүй нэмэгдсэн.

Филиппин улсад финтек үйлчилгээний эрх зүйн орчин дараах хуулиудад тулгуурлаж байна:

- Банкны тухай хууль–банкнууд болон цахим банкны үйл ажиллагаанд тавигдах шаардлага, лицензийн журам;
- Төлбөрийн системийн тухай журам–цахим төлбөрийн систем, цахим мөнгөн түрийвчид хамаарах зөвшөөрөл;
 - Мөнгө угаах, терроризмтой тэмцэх

тухай хууль – бүх финтек үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хуульд нийцэх шаардлагатай;

- Өгөгдөл хамгаалах хууль–хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, өгөгдөл цуглуулах, боловсруулахтай холбоотой зохицуулалт;
- Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний тухай хууль–токен, цахим хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн санал болгоход хамаарна.

Филиппин улсад финтекийн салбарын зохицуулалтыг дараах үндсэн төрийн байгууллагууд хариуцан хэрэгжүүлдэг:

- Филиппиний Төв банк (Bangko Sentral ng Pilipinas)–мөнгөний бодлого, төлбөрийн систем, дижитал банк, финтек үйлчилгээний ерөнхий зохицуулалт;
- Цахим харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар–цахим мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл хамгаалах бодлого;
- Үнэт цаас болон биржийн комисс–финтекийн хүрээнд санал болгож буй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний зохицуулалт;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хороод, яамд–финтекийн хэрэглэгчийн эрх зүйн хамгаалалт.

Мөн дээрх байгууллагууд хамтран Финтекийн салбарын төлөвлөгөө, дэлгэрэнгүй бодлогын хөтөлбөрүүд гарган хэрэгжүүлж байна. Төв банк нь финтекийн чиглэлээр гадаадын зохицуулагч байгууллагуудтай санамж бичиг байгуулж, технологийн шинэчлэлд

нийцсэн зохицуулалтыг хөгжүүлэх чиглэл баримталдаг.

Филиппиний Төв банк нь технологийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэхэд эерэг, дэмжигч хандлагатай бөгөөд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдал, системийн эрсдэлийг хянах үндсэн зорилттой. Уг байгууллага нь шинэ технологийг турших, бизнесийн шинэ загваруудыг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор зохицуулалтын туршилтын орчин нэвтрүүлж, тодорхой шалгууртайгаар лиценз олгодог системийг ашигладаг.

Мөн финтек компанид шаардлагатай тусгай зөвшөөрөл олгохдоо эрсдэлийн түвшин, үйлчилгээний онцлогт тулгуурласан ангилал, нөхцөл тавьдаг бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд нийцэх байдалд онцгой анхаардаг.

Филиппинд дараах төрлийн финтек үйлчилгээ хүчтэй хөгжиж байна. Үүнд:

- Цахим хэтэвч: GCash, PayMaya зэрэг платформуор дамжуулан төлбөр, мөнгөн шилжүүлэг хийх үйлчилгээ;
- Цахим төлбөрийн систем: гар утсаар төлбөр төлөх, гүйлгээ хийх боломжийг өргөн хүрээнд ашиглаж байна;
- Дижитал банк: зөвхөн цахимаар үйл ажиллагаа явуулдаг банкнуудын тоо өсөж, лицензжүүлэлт нэмэгдсэн;
- “Одоо аваад дараа төл” үйлчилгээ, цахим зээл, жижиг дүнтэй хөрөнгө оруулалтын платформ зэрэг зээл, хөрөнгө оруулалттай холбоотой шинэ төрлийн үйлчилгээ бий болжээ;

- Криптовалют ба блокчэйн технологийн хэрэглээ өсөж байгаа боловч зохицуулалт болгоомжтой, зөвшөөрөл шаарддаг.

Филиппин улс нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор финтекийг нийгмийн үйлчилгээнд уялдуулж, алслагдсан бүсийн иргэдэд банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилго тавьж байна.

Сэндбоксын дараах зохицуулалт: Филиппин Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд тус тусдаа сэндбокс зохицуулалтыг хэрэгжүүлдэг бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран ялгаатай байдлаар хэрэгждэг. Тухайлбал Төв банкны хэрэгжүүлж буй сэндбоксын тухайд амжилттай туршигдсан финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл авах эсхүл тусгай зөвшөөрөлтэй банк, санхүүгийн байгууллагатай хамтрах замаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг шаарддаг. Эдгээрийн алинд ч хамаарахгүй цоо шинэ төрлийн үйлчилгээ байх тохиолдолд шинэ төрлийн зөвшөөрөл олгох замаар зохицуулдаг.

Харин Филиппин Улсын Үнэт цаас болон биржийн комиссын тухайд сэндбоксад хамтын санхүүжилтийн платформ, крипто хөрөнгө санал болгох үйлчилгээ гэсэн 2 үйлчилгээ амжилттай туршигдсан. Хамтын санхүүжилтийн зохицуулалт тус улсад 2019 онд нэвтэрсэн байсан тул тус зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулж буй бол дижитал хөрөнгийн биржийн зохицуулалтыг

гаргахаар ажиллаж буй аж. Өөрөөр хэлбэл Үнэт цаас болон биржийн комисс нь сэндбокс туршилтын үр дүнд суурилан зохицуулалтын дүрэм, журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах хэлбэрээр ажиллаж байна.

Филиппиний Даатгалын хорооны хувьд технологийн компаниудыг даатгалын компаниудтай хамтран ажиллах замаар зохицуулалтад оруулах үндсэн зорилгоор сэндбоксыг хэрэгжүүлдэг бөгөөд сэндбоксад үйлчилгээгээ турших байгууллагыг даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байхыг эсхүл зөвшөөрөлтэй байгууллагатай хамтарч ажиллахыг шаарддаг.

3.2.7. Их Британи Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Их Британи нь дэлхийн финтекийн төвүүдийн нэг бөгөөд Лондон хот нь олон улсын хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэл, санхүүгийн инновацын гол төв болсон. Тус улс нь дижитал санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг анхлан нэвтрүүлж, шинэ бизнес загваруудыг дэмжих зохистой хууль эрх зүйн орчин бүрдүүлснээр финтекийн салбарыг дэлхийн хэмжээнд тэргүүлэх хэмжээнд хүргэсэн.

Их Британи нь финтек салбарыг зохицуулахдаа “уян хатан, эрсдэлийн суурьтай” (principles – based, risk – based) аргачлалыг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь хууль тогтоомжийг нарийн жагсаалтаар биш, харин ерөнхий зарчимд суурилсан байдлаар хэрэгжүүлэх боломжийг олгодог. Үүний үндэс нь 2000 онд батлагдсан “Санхүүгийн үйлчилгээ ба зах зээлийн тухай хууль”

(Financial Services and Markets Act 2000, FSMA 2000) бөгөөд энэ хуулиар Санхүүгийн Үйлчилгээний Зохицуулагч байгууллага (FCA) болон Төв Банк (Bank of England, PRA) нь зохицуулалтын бүрэн эрхээ эдэлдэг (Ferran, 2001).

Финтек нь өөрөө “санхүүгийн үйлчилгээ” ангилалд багтдаг учир FSMA 2000–ын дагуу лицензтэй үйл ажиллагаа явуулах ёстой. Гэвч шинэ технологи, инновац гарч ирэхтэй зэрэгцэн FCA нь уламжлалт зохицуулалтын хандлагыг зөөллөх, хуульд нийцсэн боловч дэмжих механизм (supportive regulation) хэрэгжүүлдэг. Үүнийг 2021 оны Kalifa Review of UK Fintech–т онцолсон бөгөөд төрийн бодлого нь “innovation–friendly” хандлагыг эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэхэд чиглэж байгааг тэмдэглэсэн (Kalifa, 2021). Финтекийн салбар нь Их Британид эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа бөгөөд хөрөнгө оруулалт, гарааны бизнесүүдийн тоо, зах зээлийн багтаамжаар Европт тэргүүлдэг. Тус улсын финтекийн хөгжлийг ковид–19 цар тахал улам хурдасгаж, дижитал банк, цахим зээл, хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө удирдлага, даатгалын технологи зэрэг үйлчилгээнүүдийг олон нийт өргөн ашиглах болсон.

Их Британийн финтекийн салбарыг дараах үндсэн байгууллагууд хариуцан зохицуулдаг:

- Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Зохицуулагч Байгууллага – санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үүрэгтэй;

- Их Британийн Худалдаа, Үйлдвэрийн Яам–финтекийн салбарт төрийн бодлого, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг;
- Их Британийн Хэрэглэгчийн Эрхийг Хамгаалах Байгууллага–хэрэглэгчийн эрх ашиг, шударга өрсөлдөөнийг хянадаг;
- Их Британийн Төв банк–мөнгөний бодлого, төлбөрийн систем, криптовалюта холбоотой зохицуулалтыг боловсруулахад мөн оролцдог.

Түүнчлэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Финтекийн бодлогын форум, Финтекийн зөвлөл, Шинэчлэлтийн хөтөлбөрүүд хэрэгждэг.

Финтекийн салбарыг дараах үндсэн хуулиар зохицуулж байна:

- Санхүүгийн үйлчилгээний тухай хууль –банк, үнэт цаас, хөрөнгө оруулалттай холбоотой бүх төрлийн үйлчилгээнд хамаардаг;
- Электрон мөнгөн гүйлгээний тухай журам–төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөн түрийвч, гүйлгээний платформуудад хамаарна;
- Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль –бүх финтек үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэл цуглуулах, илрүүлэх, тайлагнах үүрэгтэй;
- Өгөгдөл хамгаалах тухай хууль (GDPR–тэй дүйцэх зохицуулалт)–хэрэглэгчийн мэдээлэл, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах журам;
- Хөрөнгө оруулалтын хуулиуд–

криптовалют, токен санал болголт, хөрөнгө оруулалтын зөвлөгөө үзүүлэхэд хамаарах зохицуулалт.

Их Британи нь салбар тус бүрийн хууль тогтоомжид үндэслэсэн уян хатан, эрсдэлд суурилсан зохицуулалтын загвар хэрэгжүүлдэг. Финтек үйлчилгээ үзүүлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээндээ тохирсон зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулна. Зохицуулалтын хандлага нь:

- Эрсдэлийн ангилалд тулгуурласан, хувьсах зохицуулалт;
- Инновацад ээлтэй, туршилтад нээлттэй зохицуулалт;
- Хэрэглэгчийн эрх хамгаалалт, өгөгдөл хамгаалалтыг тэргүүнд тавих;
- Санхүүгийн тогтвортой байдлыг хангах олон агентлагийн уялдаа.

Их Британид дараах төрлийн финтек бүтээгдэхүүн, үйлчилгээ амжилттай хөгжиж, нийт иргэд болон бизнесүүдийн өдөр тутмын хэрэглээнд бүрэн нэвтэрсэн байна:

- Цахим банк ба необанк: Starling Bank, Monzo зэрэг зөвхөн цахимаар үйл ажиллагаа явуулдаг банкууд нь хэрэглэгчдийн тоогоор улам бүр нэмэгдэж, уламжлалт банкны зах зээлийг орлож эхэлж байна.
- Цахим мөнгөн түрийвч, шилжүүлэг, цахим төлбөрийн платформууд (Revolut, Wise зэрэг)–гадаад, дотоодын төлбөрийг хялбар, хямд шийдлээр дамжуулдаг.
- Хөрөнгө оруулалтын автомат зөвлөхүүд (robo–advisors)–хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө

удирдлагын шийдлүүд.

- Криптовалют, блокчэйн үйлчилгээ–хэрэглэгчдэд зориулсан крипто түрийвч, биржийн үйлчилгээ, ухаалаг гэрээний платформууд.
- “Одоо аваад дараа төл” үйлчилгээ, цахим зээлийн платформ, жижиг бизнесийн санхүүжилтийн систем.

Тус улсад финтекийн бүтээгдэхүүн нь уламжлалт санхүүгийн тогтолцоотой нягт уялдаа холбоотойгоор хөгжиж, банкны салбарт хүчтэй өрсөлдөөн бий болгосон.

Сэндбоксын дараах зохицуулалт: Их Британи Улсын сэндбокс зохицуулалт нь зөвхөн туршилтын зорилгоор ашиглагддаг бөгөөд сэндбоксад хамрагдсанаараа аливаа төрлийн зохицуулалтын шаардлагаас зайлсхийх эсхүл хөнгөвчилсэн, түргэвчилсэн хэлбэрээр шаардлагатай зөвшөөрлийг авах нөхцөл болохгүй. Амжилттай туршигдсан үйлчилгээг холбогдох шаардлагаа ханган зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулахыг шаарддаг. Тус улсад сэндбоксын дэргэд инновацын зөвлөх үйлчилгээ мөн хэрэгждэг бөгөөд сэндбоксад амжилттай туршигдсан үйлчилгээг албан ёсны зөвшөөрлөө аван зах зээлд бүрэн нэвтрэхэд зөвлөн туслах зорилготой менежерүүдийг бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр нь хуваарилдаг. Олон санхүүгийн байгууллага зөвхөн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршихаас гадна зохицуулалтын шаардлагыг таних замаар аажмаар зах зээлд нэвтрэхийн тулд сэндбоксыг сонгодог.

Мөн сэндбоксад туршигдсан бүх үйлчилгээ

нь зөвшөөрөлтэй үйл ажиллагаа байх шаардлагагүй бөгөөд амжилттай туршигдсан зарим үйлчилгээг зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулахыг зөвлөх тохиолдлууд байдаг. Түүнчлэн сэндроксод амжилттай туршигдсан байгууллагууд тусгай зөвшөөрөлтэй банк, санхүүгийн байгууллагуудтай хамтрах замаар үйл ажиллагаагаа зах зээлд нэвтрүүлэх тохиолдлууд түгээмэл байдаг.

Хэрэв сэндроксын туршилтын үр дүнд зохицуулалтын хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлага үүсвэл Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага нь Сангийн яамтай хамтран холбогдох өөрчлөлтийг оруулдаг. Их Британи Улсын сэндрокс зохицуулалтын тухайд зохицуулалтын орчны өөрчлөлт, шинэчлэлтээс илүүтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний бизнес загвар, технологийг туршихад чиглэсэн байдаг ба амжилттай туршигдсан үйлчилгээг зохицуулалтын шаардлага заавал хангахыг шаарддаг тул сэндроксоос амжилттай гарсан төслийн тоо харьцангуй бага байна.

3.2.8. Швейцар Улс

Хууль, эрх зүйн зохицуулалт: Швейцар улс нь дэлхийд санхүүгийн тогтвортой байдлаараа алдартай бөгөөд энэ орчин нь финтекийн инновацыг идэвхтэй хөгжүүлэх үндэс суурь болж өгдөг. Тус улсын финтекийн зах зээл сүүлийн арван жилд эрчимтэй тэлж, олон улсын хөрөнгө оруулагчид, гарааны компаниудын сонирхлыг татах болжээ. Төв байр нь Цюрих болон Женев хотуудад

төвлөрсөн бөгөөд олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий финтек үйлчилгээ үзүүлэгчид үүсэж бий болсон.

Швейцарт уламжлалт банк, хөрөнгө оруулалтын байгууллагууд финтек технологийг идэвхтэй нэвтрүүлж байгаа бөгөөд блокчэйн, криптовалюта, дижитал зээл, цахим банкны шийдлүүд энэ салбарыг түүчээлж байна. Уг улс нь “Крипто хөндий” гэх нэрээр олон улсад танигдсан Цуг мужид төвлөрсөн криптовалюта, блокчэйн компаниудын бөөгнөрөл бий болгосон нь технологийн кластер болон хөгжиж байгаа юм.

Швейцар улсад финтекийн зохицуулалт нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилсан, төвлөрсөн бус системтэй бөгөөд дараах гол байгууллагууд үүрэг гүйцэтгэдэг:

- Швейцарын Санхүүгийн Зах Зээлийг Хянан Зохицуулах Алба–финтекийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, хяналт, хөрөнгө оруулалтын зохицуулалтыг хэрэгжүүлдэг гол байгууллага;
- Швейцарын Үндэсний Банк– мөнгөний бодлого, төлбөрийн систем, дижитал франкийн судалгаа;
- Холбогдох орон нутгийн байгууллагууд –блокчэйн болон криптовалютын үйлчилгээтэй холбоотой бизнесийг мужийн түвшинд дэмждэг;
- Мэдээлэл хамгаалах газрууд– хэрэглэгчийн өгөгдөл, нууцлалын эрхийг хамгаалах асуудалд хяналт тавьдаг.

Эдгээр байгууллагуудын уялдаа, нарийн

ялгаатай зохицуулалт нь санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрх зүйн тодорхой байдлыг хангаж өгдөг.

Швейцарын зохицуулалт нь инновацыг дэмжих, эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах гэсэн гурван тулгуурт үндэслэсэн. Зохицуулалт нь технологид төвлөрөхөөс илүүтэй тухайн үйл ажиллагааны шинж чанарт суурилдаг бөгөөд үүгээрээ олон улсын жишигт нийцсэн уян хатан тогтолцоотой гэдгээрээ ялгардаг.

2017 онд тусгай финтекийн зөвшөөрөл бий болсон ба энэ нь банкны тусгай зөвшөөрөл шаардагдахгүйгээр тодорхой хэмжээний хадгаламжийн үйлчилгээ үзүүлэхийг хүртэл зөвшөөрдөг. Ингэснээр гарааны бизнесүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн боломж нээгдсэн. Мөн зохицуулалтын сэндрокс туршилтын орчныг албан ёсоор байгуулалгүйгээр, хууль эрх зүйн уян хатан байдлаар туршилтыг дэмжих тогтолцоо бүрдүүлсэн байдаг.

Швейцарын зохицуулалт нь:

- Эрсдэлийн ангилалд тулгуурласан шаталсан зөвшөөрөл;
- Хууль ёсны, өрсөлдөх чадвартай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн;
- Мэдээлэл хамгаалалт, мөнгө угаахын эсрэг хүчтэй хяналт;
- Криптовалют болон блокчэйн технологид тусгай анхаарал хандуулсан.

Швейцар улсад дараах төрлийн финтек үйлчилгээ түлхүү хөгжиж байна:

- Цахим мөнгөн түрийвч болон төлбөрийн системүүд–хэрэглэгчид

банкны гүйлгээ, төлбөрийг хялбар гүйцэтгэх боломжтой;

- Дижитал банк болон мобайл банкны үйлчилгээ–банкнууд финтек технологид тулгуурлан хэрэглэгчдэдээ илүү хүртээмжтэй үйлчилгээ санал болгож байна;
- Блокчэйн суурилсан үйлчилгээ –ухаалаг гэрээ, токенжуулалт, хөрөнгийн цахим бирж зэрэг үйлчилгээнүүд;
- Криптовалютын үйлчилгээ–крипто бирж, хадгаламж, зоос гаргалт зэрэг;
- Хөрөнгө оруулалтын автомат зөвлөх үйлчилгээ–өгөгдлийн шинжилгээнд суурилсан хөрөнгийн удирдлага;
- “Одоо аваад дараа төл” үйлчилгээ, цахим зээл, жижиг бизнесүүдэд зориулсан санхүүжилтийн цахим системүүд.

Швейцарын онцлог нь блокчэйн болон криптовалюттай холбоотой финтек үйлчилгээ өндөр төвшинд хөгжсөн бөгөөд энэ чиглэлээр дэлхийн хэмжээнд тэргүүлэгчдийн нэг болжээ.

Финтекийн үйл ажиллагаа дараах гол хууль, зохицуулалтаар зохицуулагдана:

- Банкны тухай хууль–банкны үйлчилгээ, хадгаламж, зээлийн нөхцөлд хамаарна;
- Финтекийн тусгай зөвшөөрлийн журам–бага эрсдэлтэй санхүүгийн үйлчилгээ эрхлэх компаниудад зориулсан эрх зүйн зохицуулалт;
- Криптовалют болон блокчэйн технологийн тухай удирдамж–токен

санал болголт, арилжаа, хадгаламж зэрэг;

- Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль–бүх финтек үйлчилгээ үзүүлэгч

байгууллага хамаарна;

- Өгөгдөл хамгаалах тухай хууль–хэрэглэгчийн мэдээлэл, цахим нууцлалд хамаарна.

Хүснэгт 4. Улс орнуудын финтекийн зохицуулалт

Улс	Зохицуулалт	Тусгай зөвшөөрөл	Зохицуулагч байгууллага	Зохицуулалтын хандлага
Казахстан	Хосолмол зохицуулалт: Үндэсний хууль болон Астана олон улсын санхүүгийн төвийн тусгай эрх зүй	Санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл; крипто, финтек, туршилтын орчны зөвшөөрөл	Үндэсний банк; Астана олон улсын санхүүгийн төвийн Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч; Санхүүгийн зах зээлийн агентлаг	Инновацыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, уян хатан, эрсдэлд суурилсан хандлага
Сингапур	“Төлбөрийн үйлчилгээний тухай хууль” зэрэг нэгтгэсэн зохицуулалттай	Санхүүгийн үйлчилгээ, цахим мөнгө, крипто үйлчилгээний тусгай зөвшөөрөл	Сингапурын Санхүүгийн Захиргааны газар	Хөнгөн, эрсдэлд суурилсан, инновацад нээлттэй, удирдамжаар чиглүүлдэг
Филиппин	Төрөөс баталсан финтекийн стратеги, Төлбөрийн үйлчилгээ, Мөнгө угаахын эсрэг хууль	Цахим мөнгө, дижитал банк, зээл, крипто үйлчилгээний тусгай зөвшөөрөл	Филиппиний Төв банк; Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар; Үнэт цаасны комисс	Хэрэглэгчийн хамгаалалтад суурилсан, зохицуулалтын туршилтыг дэмждэг, эрсдэлийн ангилалд тулгуурладаг
Их Британи	Санхүүгийн үйлчилгээний тухай хууль, зохицуулалтын туршилтын орчны журам	Санхүүгийн үйлчилгээ, финтек бүтээгдэхүүнд тусгай зөвшөөрөл	Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч; Их Британийн Төв банк	Эрсдэлд суурилсан, инновацыг турших sandbox системтэй, маш сайн тодорхойлогдсон стандарт бүхий хандлага
Япон	Цахим санхүүгийн гүйлгээ, криптовалютын хууль, сэндрокс туршилтын зохицуулалт	Финтек үйлчилгээ, крипто арилжаа, цахим мөнгөний тусгай зөвшөөрөл	Японы Санхүүгийн үйлчилгээний хороо; Төв банк	Хуульчлагдсан, өндөр шаардлагатай боловч инновацад уян хатан

Швейцар	Финтекийн тусгай зөвшөөрөл бүхий хууль эрх зүйн систем	Банкны болон финтекийн тусгай зөвшөөрөл; крипто, блокчэйнд зориулсан лиценз	Швейцарын Санхүүгийн Зах Зээлийн Зохицуулагч; Үндэсний банк	Технологийн төвийг сахисан, үйл ажиллагаанд суурилсан, хөрвөх чадвартай зохицуулалт
Өмнөд Солонгос	“Санхүүгийн инновацыг дэмжих тухай хууль” санхүүгийн бусад хууль	Инновацын үйлчилгээний зөвшөөрөл, цахим мөнгө, P2P зээл, дижитал банк	Санхүүгийн үйлчилгээний хороо; Санхүүгийн хяналтын газар	Sandbox, эрсдэлд суурилсан зохицуулалт; инновацад онцгой дэмжлэгтэй
Мексик	“Финтекийн тухай хууль” бүс нутгийн анхны иж бүрэн финтек хууль	Санхүүгийн технологийн байгууллагын тусгай зөвшөөрөл; цахим мөнгө, краудфандинг, виртуал хөрөнгө	Мексикийн Төв банк; Сангийн яам; Санхүүгийн хяналтын байгууллагууд	Удирдлагын 6 зарчимд суурилсан; идэвхтэй шинэчлэгддэг зохицуулалт

Дээр дурдсан орнуудын жишээн дээр үндэслэн авч үзвэл, финтек (санхүүгийн технологи) салбарын зохицуулалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоо, зохицуулалтын байгууллага, зохицуулалтын хандлага нь улс орон бүрд өөр боловч нийтлэг чиг хандлага, зарим ижил төстэй байдал илэрч байна.

Зохицуулалтын нийтлэг хандлагууд

Финтекийг зохицуулах нийтлэг хандлага, зарчим дараах байдлаар ажиглагдаж байна:

- **Сэндбокс механизм:** Ихэнх орнууд туршилтын зохицуулалтын орчныг нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээнд, хяналт дор турших боломж олгож байна. Үүнд Их Британи, Сингапур, БНСУ, Филиппин, Мексик, Бразил,

Бахрейн зэрэг орнууд багтана.

- **Эрсдэлд суурилсан зохицуулалт:** Сингапур, Их Британи, Япон зэрэг орнууд нь технологийн эрсдэлийг үнэлэн уян хатан, мэргэжлийн зохицуулалтын арга хэрэглэж байна.
- **Инновацыг дэмжсэн уян хатан орчин:** БНСУ, Бахрейн зэрэг орнууд хуульчлагдсан чөлөөт бүс (sandbox zone) болон инновацын төвүүдийг ажиллуулж, эрх зүйн хөнгөлөлт үзүүлдэг.
- **Хил дамнасан зохицуулалтын уялдаа:** Европын Холбоо, Сингапур зэрэг орнууд нь олон улсын стандартад нийцсэн, хил дамнасан санхүүгийн үйлчилгээний зохицуулалтыг боловсруулж байна.

3.2.9. Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт

Хууль, эрх зүйн зохицуулалт: Монгол улсад финтек салбар сүүлийн жилүүдэд харьцангуй хурдтай хөгжиж байгаа. Эдийн засгийн өсөлт, технологийн дэвшил болон интернэтийн хэрэглээний түвшин өндөр байгаагаас үүдэн финтекийн үйлчилгээ хэрэглэх нь нэмэгдсээр байна. Дараах үйлчилгээнүүд голлон хөгжиж байна:

- Дижитал төлбөр тооцоо: Монголд гар утсанд суурилсан, цахим банк, QR код ашигласан төлбөрийн системүүд эрчимтэй хөгжиж байгаа.
- Хадгаламж болон зээл: Технологийн компанийн зээлийн үйлчилгээ, онлайн зээлийн платформууд хөгжиж байна.
- Блокчэйн болон криптовалюта: Криптовалют болон блокчэйн технологи нь Монгол улсад албан ёсны зохицуулалтгүй боловч сонирхолтой салбар болж байгаа.
- Иргэдийн санхүүгийн менежмент: Үүний хүрээнд олон төрлийн санхүүгийн платформууд хэрэглэгчдийн хэрэглээг илүү хялбар болгох зорилгоор хэрэгжиж байна.

Голлох технологиудын хувьд:

- Мобайл төлбөрийн системүүд: Mongol Pay, E-Mongolia, QPay зэрэг мобайл үйлчилгээнүүд Монголын зах зээлд гол технологи болж байна.
- API болон интеграци: Монголын банкнууд болон финтекийн компаниуд хоорондоо API ашиглаж, үйлчилгээний хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

- Блокчэйн: Монголын санхүүгийн зах зээлд блокчэйн технологийг судалж, ашиглах сонирхол нэмэгдэж байна.

Монгол Улсад финтекийн үйл ажиллагааг дараах хуулиудын хүрээнд зохицуулж буй хэдий ч хуулиар зохицуулагдах үйлчилгээг нарийвчлан заасан байдаг нь зах зээлд шинэ үйлчилгээ нэвтрэхэд сул тал болж байна. Үүнд:

- Төлбөрийн үйлчилгээний тухай хууль (2021 он)–цахим мөнгө, төлбөрийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, төлбөрийн систем, түрийвчний үйлчилгээ зэрэгт хамаарах зохицуулалтыг тусгасан;
- Цахим гарын үсгийн тухай хууль, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим орчны аюулгүй байдлын тухай хууль (2023 он)–финтекийн цахим орчинд тавигдах шаардлага, хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, өгөгдлийн нууцлал, кибер аюулгүй байдлыг зохицуулж байна;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль–хувьцааны хамтын санхүүжилт болон зарим төрлийн шинэ үйлчилгээнд хамаарах зохицуулалтыг тусгаж эхэлсэн;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль–нарийвчлан заасан 9 төрлийн үйл ажиллагаанд хамааран хэрэгждэг, финтек зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах зэрэг финтекийн үйл ажиллагаа тус хуулийн хүрээнд зохицуулагддаг;

- Даатгалын тухай хууль–даатгалын тухай хууль болон бусад зохицуулалтын журмаар даатгалын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөл бүрдсэн;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль– виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хууль.

Монгол улсад Финтек салбарын хөгжлийг одоогоор Сангийн яам, Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтын ажиллагааны хүрээнд янз бүрийн агентлаг хоорондын зохицуулах байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монголбанк–төлбөр тооцооны систем, цахим мөнгөн хөрөнгө, дижитал банк зэрэг шинэ үйлчилгээний хүрээнд хяналт тавьдаг;
- Санхүүгийн зохицуулах хороо–банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хөрөнгийн зах зээл, цахим мөнгө, краудфандинг (олон нийтээс хөрөнгө босгох үйлчилгээ) зэрэг секторт хяналт тавьж, зарим финтек төрлийн үйлчилгээг хариуцдаг;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Кибер аюулгүй байдлын газар–мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалахтай холбогдох зохицуулалтыг хариуцдаг.

Түүнчлэн Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Сэндбоксын зөвлөлүүд

байгуулагдан санхүү, технологийн зохицуулагч байгууллагуудын хамтарч ажиллах боломжийг бүрдүүлж байна. Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны оролцоотойгоор зөвхөн шаардлагатай үеүдэд Финтек инновацтай холбоотой асуудлуудыг хэлэлцдэг. Гэсэн хэдий ч эдгээр байгууллагууд нь үндэсний төлбөрийн системийн зохицуулалт, хяналт болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бөгөөд финтекийн хөгжлийг чиглүүлэх нь тэдний эрх мэдлийн хүрээнд албан ёсоор багтаагүй. Мөн санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудаас бусад төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо хязгаарлагдмал бөгөөд финтекийн хөгжил, санхүүгийн зохицуулах байгууллагуудаас гаргаж буй шинэ төрлийн зохицуулалтыг бусад төрийн байгууллагууд төдийлөн бүрэн ойлгодоггүй зэрэг асуудлууд байна.

Сэндбоксын дараах зохицуулалт: Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 оноос эхлэн сэндбокс зохицуулалтыг нэвтрүүлэн хэрэгжүүлж буй бөгөөд өнөөгийн байдлаар 8 байгууллага сэндбоксад орон үйл ажиллагаагаа явуулж байна. Гэсэн хэдий ч амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд холбогдох зохицуулалтын орчин нь үүсээгүй, шинэ төрлийн үйлчилгээг бүртгэх, зөвшөөрөл олгох эрх нь Санхүүгийн зохицуулах хороонд олгогдоогүй зэрэг асуудлууд үүсэж байна.

Санхүүгийн салбарт хүчин төгөлдөр

мөрдөгдөж буй хуулиуд нь тухайн хуулиудад хамаарах үйл ажиллагааг нарийвчлан заасан байдаг нь шинэ төрлийн үйлчилгээ зах зээл нэвтрэх тухай бүр хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг үүсгэж байна. Хуульд өөрчлөлт оруулах нь цаг хугацаа ихээхэн шаарддагаас үүдэн амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд хугацаа их авах тохиолдлууд гардаг. Энэхүү нөхцөл байдалд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 124/75/А/86

тоот хамтарсан тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж шаардлагатай зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацаанд санхүүгийн зохицуулагч байгууллага түр зохицуулалтыг хэрэгжүүлж болох эрхийг авсан. Тус нэмэлт өөрчлөлт нь амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндрбоксоос гаргах нэг арга хэрэгсэл болж буй хэдий ч түр хугацаатай хэрэгжих зохицуулалт тул шинэ үйлчилгээнд тохирсон хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага хангагдахгүй хэвээр байна.

IV. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ФИНТЕК САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Олон улсын байгууллагууд бодлогын хувьд нийтлэг финтекийн зохицуулалтад үйл ажиллагааны төрөл тус бүрд зориулсан салангид, чиглэсэн зохицуулалтын хандлага болох Модуляр зохицуулалтыг хэрэгжүүлэхийг илүүд үзэж байна. Энэхүү

зохицуулалт нь уламжлалт «нэг хууль–бүх финтек» гэдэг нэгтгэсэн загвараас ялгаатай, харин технологийн төрөл, эрсдэл, үйлчилгээний онцлогт суурилсан уян хатан тогтолцоо юм.

Хүснэгт 5. Олон улсын байгууллагуудын финтек салбарт баримталж буй бодлого, баримт бичиг

Олон улсын байгууллага	Финтек зохицуулалтын талаар баримталж буй бодлого	Баталсан баримт бичиг	Товч агуулга
Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Financial Stability Board (FSB))	Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс финтекийн эрсдэлийг урьдчилан тооцож, function-based зохицуулалтыг дэмжих	– <i>Supervisory and Regulatory Approaches to Fintech (2017)</i> – <i>Global Stablecoin Arrangements (2020)</i> – <i>Recommendations on Crypto-Assets (2023)</i>	Шинэ технологи, бизнес моделийн эрсдэлийг таньж, үйл ажиллагаанд суурилсан зохицуулалт хийхийг зөвлөсөн.

<p>Олон улсын Санхүүгийн Хориг арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force (FATF))</p>	<p>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхийн тулд финтекийг AML/CFT хүрээнд зохицуулах</p>	<p>–<i>Guidance for a Risk-Based Approach to Virtual Assets and VASPs (2019, шинэчлэгдсэн 2021)</i></p>	<p>Крипто хөрөнгө болон үйлчилгээ үзүүлэгчдэд KYC, monitoring, licensing-ийн шаардлага тавьсан</p>
<p>Олон улсын Төлбөр Тооцооны банк (Bank for International Settlements (BIS))</p>	<p>Санхүүгийн тогтолцооны үр ашиг, тогтвортой байдлыг дэмжих үүднээс төв банкнуудад зориулсан финтек чиг хандлага, технологийн үнэлгээ хийх</p>	<p>– <i>Fintech and the Future of Finance (2022)</i> – <i>Embedded Supervision (2020)</i></p>	<p>Санхүүгийн үйлчилгээ улам модуляр болж байгаа тул зохицуулалт ч мөн тийм байх ёстой гэж үзсэн.</p>
<p>Олон Улсын Валютын Сан (International Monetary Fund (IMF))</p>	<p>Финтекийн хөгжлийг санхүүгийн хүртээмж, дэд бүтцийн сайжруулалтыг дэмжихийн зэрэгцээ макро эдийн засгийн үр дагаврыг анхаарах</p>	<p>–<i>Fintech Notes: Regulating Fintech (2023)</i> – <i>Digital Money and Central Banks (2021)</i></p>	<p>Финтекийн функц, үйл ажиллагаа бүрийг өөрийн эрсдэлийн дагуу зохицуулах ёстой гэж үзсэн.</p>
<p>Дэлхийн Банк (World Bank Group (WB))</p>	<p>Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, дижитал санхүүг дэмжих, мөн зохицуулалтын орчныг сайжруулахад анхаарах.</p>	<p>–<i>Fintech and Financial Inclusion (2022)</i> – <i>Regtech, Supotech and the Role of Regulators (2021)</i></p>	<p>Хөгжиж буй орнуудад финтекийг зохистой дэмжих, хэрэглэгчийг хамгаалах</p>
<p>Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (International Organization of Securities Commissions (IOSCO))</p>	<p>Үнэт цаасны зах зээлд финтекийн үзүүлж буй нөлөөг үнэлж, хөрөнгө оруулагчийг хамгаалах чиглэлд анхаарал хандуулах</p>	<p>– <i>Policy Recommendations for Crypto and DeFi (2023)</i></p>	<p>Хөрөнгийн зах зээлд орж буй финтекийг risk-based, technology-neutral зарчмаар зохицуулах</p>
<p>Банкны хяналтын Базелийн хороо (Basel Committee on Banking Supervision (BCBS))</p>	<p>Банкнүүдын финтек эрсдэл (кредит, үйл ажиллагааны, технологийн эрсдэл гэх мэт)-ийг үнэлэх, зохистой хяналт тавих</p>	<p>–<i>Sound Practices: Implications of Fintech for Banks and Supervisors (2018)</i></p>	<p>Банк, финтекийн хамтын ажиллагааны үед үүсэх зохицуулалтын хийдлийг арилгах</p>

<p>Олон улсын даатгалын хяналтын байгууллагын холбоо (International Association of Insurance Supervisors (IAIS))</p>	<p>Даатгалын салбарт финтекийн үр нөлөөг үнэлж, эрсдэлд суурилсан хяналт зохицуулалт санал болгох</p>	<p><i>Application Paper on the Use of Digital Technology in Inclusive Insurance (2018)</i> <i>Fintech Developments in the Insurance Sector (2020)</i> <i>Issues Paper on the Use of Big Data Analytics in Insurance (2020)</i></p>	<p>Даатгалын салбартай холбоотой эрсдэлийг тодорхойлж, хяналтын чиглэл санал болгосон</p>
--	---	--	---

V. ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Нээлттэй санхүүгийн экосистем (open banking): Бразил, Их Британи, Европын холбоо зэрэг улс орнууд нь хэрэглэгчийн өгөгдлийг гуравдагч этгээдэд нээлттэйгээр өгөх эрхзүйн орчныг бүрдүүлж байна.

Эрсдэлд суурилсан, уян хатан зохицуулалттай орнууд (жишээ нь: Их Британи, Сингапур, Швейцар) нь финтекийн хөрөнгө оруулалт, инновацын чадавхаар тэргүүлж буй бол бүтээгдэхүүн төвтэй зохицуулалттай орнуудад хууль нь илүү нарийвчлалтай, тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг удирдах чиглэлд давуу байж болох ч шинэ төрлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд сул тал болж байна.

Финтекийн зохицуулалтын хамгийн үр дүнтэй хандлага бол эрсдэлд суурилсан, технологид төвийг сахисан, инновацыг дэмжсэн уян хатан тогтолцоо юм. Ингэснээр компаниуд зах зээлд хурдан нэвтэрч, хэрэглэгчийг хамгаалж, зах зээлийн өрсөлдөх чадвар өсдөг. Харин хэт хуульчилсан, бүтээгдэхүүн төвтэй зохицуулалт нь шинэ бизнесүүдийг

сааруулж, зохицуулалтаас зайлсхийх шалтгаан болдог.

Финтекийн салбарын зохицуулалт нь уламжлалт санхүүгийн хууль эрх зүйн тогтолцооны хязгаарлалтыг даван туулж, шинэ технологид уян хатан хариу үйлдэл үзүүлэх шаардлагад үндэслэн хөгжиж байна. Салбарын шинж чанар, эрсдэл, хэрэглэгчийн оролцооны түвшнийг харгалзан дараах нэгдсэн хандлагууд ажиглагдаж байна:

1. Эрсдэлд суурилсан, уян хатан зохицуулалт (Risk-based, adaptive regulation)

Бүх улс орнууд шинэ технологийг шууд хориглох бус, түүний үзүүлэх эрсдэлийг үнэлэх замаар зохицуулах бодлого баримталж байна. Энэ нь:

- Тусгай зөвшөөрлийг үйлчилгээний шинж чанар, эрсдэлийн түвшингээр ялгаж олгох;
- Эрсдэл багатай жижиг үйлчилгээ үзүүлэгчдэд зохицуулалтын дарамтыг багасгах;
- Криптовалют зэрэг шинэ хөрөнгийн

ангиллыг зөвшөөрөлтэй, хяналттай хүрээнд хөгжүүлэх нөхцөл бүрдүүлж байна.

2. Инновацад ээлтэй, туршилтын зохицуулалт (Pro-innovation, sandbox-driven regulation)

Ихэнх улс орнууд зохицуулалтын туршилтын орчин сэндрбоксыг нэвтрүүлсэн ба үүгээрээ инновацлаг финтек үйлчилгээг хуулийн хүрээнээс түр хугацаанд чөлөөлж, хэрэглэгчийн эрсдэлийг бага хүрээнд турших боломж олгож байна. Үүнд төрийн зөвшөөрөл, эрсдэлийн дүн шинжилгээ, тодорхой хугацааны хязгаарлалт зэрэг хяналтын механизм багтдаг.

3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэл (Consumer-protection-focused)

Финтекийн үйлчилгээ нь шууд хэрэглэгчтэй харилцдаг учраас хэрэглэгчийн мэдээлэл, өгөгдөл, хөрөнгийг хамгаалах хууль эрх зүйн орчин маш чухал. Үүнд:

- Хувийн мэдээллийн хамгаалалт (data protection);
- Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх;
- Хөрөнгө оруулагчийн эрсдэлийн талаар урьдчилан мэдээлэх тогтолцоо;
- Бодит цахим баталгаажуулалтын тогтолцоо (authentication/verification) орно.

4. Зохицуулалтын технологийн нэвтрүүлэлт (RegTech ба SupTech)

Финтек компаниуд хууль тогтоомж мөрдөх

үүргээ автоматжуулах, зардал багасгахын тулд зохицуулалтын технологи (RegTech) ашиглаж байна (жишээлбэл: KYC, AML автомат системүүд). Харин зохицуулагч байгууллагууд хяналтын технологи (SupTech) ашиглан зах зээлийн мэдээлэл цуглуулах, эрсдэлийг тооцоолох системийг боловсруулж байна.

5. Технологид төвийг сахисан хандлага (Technology-neutral approach)

Сингапур, Швейцар, Мексик зэрэг улсуудын финтекийн бодлогын нэг гол зарчим бол:

- Тухайн үйлчилгээний хэрэглэгчид үзүүлэх үр нөлөө, эрсдэлийн мөн чанарт анхаарал хандуулдаг;
- Харин үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдаж буй технологийн төрөл (блокчэйн, хиймэл оюун ухаан гэх мэт)–д тийм чухал ач холбогдол өгөхгүй, технологийн хувьд төвийг сахисан байр суурь баримталдаг.

6. Хил дамнанас зохицуулалт ба олон улсын уялдаа (Cross-border regulatory cooperation)

- Олон улсын санхүүгийн үйлчилгээ, интернэтэд суурилсан бүтээгдэхүүнтэй холбоотойгоор хил дамнанас зохицуулалтын шаардлага нэмэгдэж байна;
- Их Британи, Япон, Мексик, Сингапур зэрэг улсууд санамж бичиг, хоёр талт гэрээ байгуулж, финтекийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зохицуулалтын зарчмуудыг бий болгоход анхаарч байна.

ДУГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн зах зээл дэх технологийн дэвшил эрчимжин, санхүүгийн үйлчилгээний хэлбэр, хүрэх суваг, зах зээлийг тогтолцоог өөрчилж байна. Энэхүү өөрчлөлтийг даган санхүүгийн зохицуулагч байгууллагууд мөн уламжлалт хандлагаа эргэн харах, илүү уян хатан, эрсдэлд суурилсан, инновацад ээлтэй зохицуулалтын шийдэл боловсруулах зэргээр бодлого, зохицуулалтдаа өөрчлөлт оруулж байна.

Энэхүү судалгаагаар улс орнууд технологийн хөгжлийг даган бодлого, зохицуулалтын орчиндоо ямар өөрчлөлт, шинэчлэлт гүйцэтгэн, шинэ тутам хөгжиж буй финтек үйлчилгээг хэрхэн зохицуулж, зохицуулалтын ямар бодлого баримталж буйг судлахыг зорилоо. Улс орнууд шинэ технологи, инновацыг хатуу зохицуулах бус илүү уян хатан, эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглах, мөн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээнд туршсаны үндсэн дээр зах зээлд нэвтрүүлэх зэргээр ажиллаж байна. Түүнчлэн зарим орнууд финтек үйлчилгээг бүхэлд нь хамарсан тусгай хууль баталж (жишээлбэл, Мексик), зарим нь салбар тус бүрийн хуулиудад тусгай өөрчлөлтүүд оруулж, шинээр бий болсон бүтээгдэхүүнийг үе шаттайгаар зохицуулж байна (жишээлбэл, Их Британи, Япон).

Сэндбокс зохицуулалтын хэрэгслийг ашиглаж буй орнуудын хувьд тус зохицуулалтыг шинэ төрлийн үйлчилгээний хууль зүйн статусыг тодорхойлох, зохицуулалтын шаардлагыг боловсронгуй болгох туршилтын механизм хэлбэрээр ашиглах

тохиолдол түгээмэл байгаа юм. Манай улсын хувьд ч мөн зохицуулалтын сэндбоксыг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж буй хэдий ч сэндбоксад амжилттай туршигдсаны дараах зохицуулалт тодорхой бус хэвээр байна. Энэ нь инновацыг дэмжих чиглэлд баримталж буй бодлогын үр дүн тодорхой бус байх, зах зээлд оролцогчдын итгэлийг сулруулах зэрэг олон сөрөг үр дагавартай юм.

Улс орнууд сэндбоксын дараах зохицуулалтыг дараах байдлаар шийдвэрлэж байна. Үүнд: шинэ төрлийн тусгай зөвшөөрлийн ангилал бий болгох (Казахстан, Филиппин), түр зөвшөөрөл, хяналтын гэрээ, үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй тухай захидал зэргийг ашиглан завсрын зохицуулалт хэрэгжүүлэх (Япон, Их Британи), мөрдөгдөж буй хуулиуддаа нэмэлт өөрчлөлт оруулж, шинэ бүтээгдэхүүнийг эрх зүйн хүрээнд хамруулах (Мексик, Швейцар) зэргээр амжилттай туршсан үйлчилгээг албан ёсны хэлбэрт шилжүүлж байна.

Түүнчлэн, технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ нь зөвхөн санхүүгийн зохицуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд өгөгдөл хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх зүйн хамгаалалт зэрэг олон талт зохицуулалт шаарддаг. Иймээс улс орнуудын зохицуулагч байгууллагууд салбар хоорондын хамтын ажиллагаа, институтын уялдааг шинэ түвшинд гаргаж, финтек зохицуулалтын олон талт бүтэц бий болгож байна.

Судалгааны үр дүнгээс харахад инновацыг дэмжсэн, технологид төвийг сахисан,

эрсдэлд суурилсан зохицуулалт нь хамгийн өргөн хэрэглэгдэж, өндөр үр дүн өгч буй жишиг болох нь харагдав. Тухайлбал, Сингапур, БНСУ, Мексик зэрэг улс орнууд сэндрбоксоор дамжуулан шинэ төрлийн санхүүгийн үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, амжилттай туршсан бүтээгдэхүүнийг зах зээлд бүрэн нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл, журам, хуулийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд финтекийн өсөлт хурдацтай явагдаж байгаа ч шинэ үйлчилгээ зах зээлд нэвтрэхэд зохицуулалтын тодорхой бус байдал үүсэх, санхүүгийн зохицуулагч байгууллагуудад тухайн үйлчилгээг бүртгэх, зөвшөөрөх эрх зүйн боломж байхгүй байх зэрэг нөхцөлүүд үүсэж байна. Энэ нь салбарын зохицуулалтын хуулиудаа илүү өргөн хүрээний болгон шинэчилж, инновацад нээлттэй эрсдэлд суурилсан, уян хатан зохицуулалт руу шилжих эсхүл шинэ төрлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх шаардлагатай болгож буй юм.

Судалгааны үр дүнд суурилан дараах саналуудыг боловсрууллаа:

- Мексик, Өмнөд Солонгос улсуудын адилаар шинэ төрлийн финтекийн үйлчилгээг зохицуулах бие даасан хууль боловсруулах эсхүл салбарын хуулиуддаа өөрчлөлт оруулж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хамарсан зохицуулалтыг бий болгох. Энд шинээр гарах бүтээгдэхүүн, үйлчилгээг урьдчилан харах боломжгүй тул салбарын хуулиудад илүү ерөнхий хэлбэрийн өөрчлөлтүүдийг оруулах;
- Санхүүгийн байгууллагуудыг үйл

ажиллагааны цар хүрээ, хэмжээнээс нь хамааран ялгаатай байдлаар хянаж, зохицуулах эрсдэлд суурилсан илүү уян хатан зохицуулалтыг нэвтрүүлэх. Тодорхой хэмжээний босгыг давсан томоохон санхүүгийн байгууллагуудын хяналтад түлхүү анхааран гарааны бизнесүүд, бага хэмжээтэй оролцогчдын зохицуулалтын шаардлагуудыг ялгаатай тогтоох. Эрсдэлийн түвшингээс нь хамааруулан зарим бүтээгдэхүүн, үйлчилгээнд зөвхөн цөөн тооны зайлшгүй хяналтыг тавин, бүртгэх зохицуулалтыг хэрэгжүүлэх (мөнгө угаах эрсдэлийн хяналтыг заавал хэлбэрээр гэх мэт).

- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулсан “түр зөвшөөрөл”, “хяналтын гэрээ”, “үйл ажиллагааг хориглоогүй” гэх мэт хэрэгслийг ашиглах. Сингапур, Их Британи, Япон зэрэг улсууд эрсдэл багатай шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд саадгүй нэвтрүүлэх зорилгоор тус арга хэрэгслийг ашигладаг.
- Дүрэмд суурилсан зохицуулалтаас зарчимд суурилсан шилжин заавар, зөвлөмж, стандарт хэлбэрээр зохицуулалтыг хэрэгжүүлэх. Мөн технологийн ашиглалт, өгөгдлийн аюулгүй байдал, API стандартчилал, нээлттэй санхүү зэргийг зохицуулалтын бодлого, журамдаа тусгах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтын баримт бичгүүдээ үнэлэх зэргээр технологи, шинэ үйлчилгээний эрсдэлийг хамарсан зохицуулалтыг хэрэгжүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2017). Fintech and RegTech in a Nutshell, and the Future in a Sandbox. SSRN Electronic Journal.
- Gomber, P., Kauffman, R. J., Parker, C., & Weber, B. W. (2018). On the Fintech Revolution: Interpreting the Forces of Innovation, Disruption, and Transformation in Financial Services. *Journal of Management Information Systems*.
- Catalini, C., & Gans, J. S. (2016). Some Simple Economics of the Blockchain. MIT Sloan Research Paper.
- Gai, K., Qiu, M., Sun, X., Zhao, H., & Zhang, Y. (2018). Application of Artificial Intelligence in Fintech: A Review.
- World Bank (2020). The Global Fintech Report.
- IMF (2019). The Rise of Digital Money. IMF Fintech Notes.
- Allen, H. J. (2019). Driverless finance. *Georgetown Law Journal*, 108(5), 1025–1076.
- Buckley, R. P. et al. (2021). Building fintech ecosystems: Regulatory sandboxes, innovation hubs and beyond. *Washington Univ. Journal of Law & Policy*, 65, 147–182.
- Jenik, I., & Lauer, K. (2017). Regulatory sandboxes and financial inclusion. CGAP.
- Pasti, F. et al. (2020). The role of regulation in shaping fintech innovation: The case of Kenya. World Bank.
- Zetsche, D. A. et al. (2017). Regulating a revolution: From regulatory sandboxes to smart regulation. *Fordham Journal of Corporate & Financial Law*, 23(1), 31–103.
- MAS (Monetary Authority of Singapore). (2022). FinTech Regulatory Approach.
- Astana Financial Services Authority (AFSA). (2023). Annual FinTech Report.
- Zetsche, D. A., Buckley, R. P., Arner, D. W., & Barberis, J. N. (2017). From FinTech to TechFin: The Regulatory Challenges of Data–Driven Finance. *NYU Journal of Law & Business*.
- Financial Conduct Authority (FCA). (2023). FinTech and Innovation Hub Report.
- Monetary Authority of Singapore (MAS). (2022). Singapore Fintech Strategy Overview.
- European Commission. (2018). Revised Payment Services Directive (PSD2).
- Financial Services Commission of Korea. (2020). Fintech Sandbox Report.
- Astana International Financial Centre (AIFC). (2021). Regulatory Sandbox Overview.
- Bangko Sentral ng Pilipinas (BSP). (2022). Digital Payments Transformation Roadmap.
- Monetary Authority of Singapore (MAS). (2016). FinTech Regulatory Sandbox Guidelines. <https://www.mas.gov.sg>
- Monetary Authority of Singapore (MAS). (2020). Overview of the Regulatory Sandbox and

- Sandbox Express. <https://www.mas.gov.sg>
- Low, K. (2021). Fintech Regulation in Singapore: Legal Infrastructure and Innovation. *Singapore Journal of Legal Studies*, 1(1), 25–42.
 - Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2016). The Evolution of Fintech: A New Post-Crisis Paradigm? *Georgetown Journal of International Law*, 47(4), 1271–1319.
 - Financial Conduct Authority. (2020). Regulatory Sandbox Lessons Learned Report. <https://www.fca.org.uk>
 - Financial Services and Markets Act 2000, Part 4A. <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/8/contents>
 - Arner, D. W., Barberis, J., & Buckley, R. P. (2017). FinTech and RegTech: Impact on Regulators and Banks. *Journal of Banking Regulation*, 19(4), 1–14.
 - Financial Conduct Authority (FCA). (2015). Regulatory Sandbox – Project Innovate. <https://www.fca.org.uk/>
 - AIFC FinTech Rules. (2021). Astana Financial Services Authority. <https://afsa.aifc.kz>
 - AFSA. (2020). Digital Financial Services Development Roadmap 2020–2025. Astana Financial Services Authority.
 - AFSA. (2021). Regulatory Sandbox Guidelines. <https://afsa.aifc.kz>
 - BSP. (2021a). BSP Regulatory Sandbox Framework (Circular No. 1108). Bangko Sentral ng Pilipinas. <https://www.bsp.gov.ph>
 - BSP. (2021b). FinTech Roadmap and Digital Payments Transformation Strategy 2020–2023. Bangko Sentral ng Pilipinas.
 - Zetsche, D. A., Buckley, R. P., Arner, D. W., & Barberis, J. N. (2017). Regulating a Revolution: From Regulatory Sandboxes to Smart Regulation. *Fordham Journal of Corporate & Financial Law*, 23(1), 31–103.
 - European Commission. (2022). Digital Finance Strategy for the EU. Brussels. <https://finance.ec.europa.eu>
 - European Commission. (2023). EU Digital Finance Sandbox Overview. Brussels.
 - Zetsche, D. A., Arner, D. W., Buckley, R. P. (2020). Decentralized Finance (DeFi). University of Hong Kong Faculty of Law Research Paper No. 2020/030
 - Bank of Lithuania. (2020). The Regulatory Sandbox Concept. <https://www.lb.lt>
 - Bank of Lithuania. (2021). Fintech Guidelines and Newcomer Programme. <https://www.lb.lt>
 - Bank of Lithuania. (2022). Licensing decisions and sandbox results. <https://www.lb.lt>
 - Commission de Surveillance du Secteur Financier. (2020). Innovation Hub and Support to FinTech. <https://www.cssf.lu>

- Luxembourg House of Financial Technology (LHoFT). (2021). Fintech Programmes and Regulatory Collaboration. <https://lhofit.com>
- CSSF. (2022). Annual Report: Regulatory developments on digital finance. <https://www.cssf.lu>
- Financial Services Commission (FSC). (2019). Financial Innovation Support Act Overview. Retrieved from: <https://www.fsc.go.kr>
- FSC. (2020). Korea's Fintech Regulatory Landscape. <https://www.fsc.go.kr>
- FSC. (2021). Post-sandbox evaluation and licensing criteria. Retrieved from: <https://www.fsc.go.kr>
- Park, J. (2022). South Korea's regulatory sandbox: Balancing innovation and consumer protection. *Asian Journal of Law and Economics*, 13(1), 45–62.
- Financial Services Agency (FSA). (2020). Approach to FinTech Regulation and Sandbox in Japan. Retrieved from: <https://www.fsa.go.jp>
- Ministry of Economy, Trade and Industry (METI). (2018). Launch of the Regulatory Sandbox System in Japan. <https://www.meti.go.jp>
- Nakazato, K. (2020). Japan's Sandbox Strategy: Innovation without Deregulation? *Journal of Japanese Law*, 25(1), 38–52.
- IMF. (2021). Japan: Financial Sector Assessment Program. Retrieved from: <https://www.imf.org>
- People's Bank of China (PBOC). (2020). Notice on the Launch of Fintech Innovation Regulatory Trial in Beijing. Retrieved from: <http://www.pbc.gov.cn>
- IMF. (2022). People's Republic of China: Financial Sector Assessment Program – Technical Note. <https://www.imf.org>
- Liu, H. (2022). China's Regulatory Sandbox: Experimental Governance under State Control. *Asia-Pacific Journal of Financial Studies*, 51(3), 210–235.
- KPMG China. (2021). Fintech in China: Regulation and Innovation. Retrieved from: <https://home.kpmg/cn>
- CNBV (2021). Guia de modelos novedosos bajo la Ley Fintech. Comisiy Nacional Bancaria y de Valores.
- Ley para Regular las Instituciones de Tecnología Financiera (2018). Gobierno de México.
- OECD (2020). Digital Innovation in Financial Services in Mexico: Fintech Regulation and Development. <https://www.oecd.org>
- Banco Central do Brasil. (2020). Open Banking Implementation Strategy – Brazil.
- Banco Central do Brasil. (2021). Sandbox Regulatyrrio: Regras e Critйrios de Participaзro.
- Banco Central do Brasil. (2022). Relatyrrio de Resultados do Sandbox Regulatyrrio.
- IMF. (2022). Fintech in Latin America: Innovating Financial Inclusion.
- World Bank. (2022). Brazil Digital Financial Services Review.

